

**ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН**



**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ХЭЛЦЛИЙН  
ЗАРДЛЫН СУДАЛГАА**

**Д.ГАНСУЛД  
З.МАНЛАЙБААТАР  
Ч.НАРАНТУЯА**

**УЛААНБААТАР ХОТ**

**2016 ОН**

# ТОВЬЁГ

<b>ТОВЧИЛСОН УГСИЙН ЖАГСААЛТ.....</b>	<b>3</b>
<b>ОРШИЛ .....</b>	<b>4</b>
<b>1. ЖДУ-ИЙН ИНСТИТУЦИЙН ОРЧИН, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ.....</b>	<b>6</b>
1.1. Институцийн эдийн засаг .....	6
1.2. Бизнесийн орчны үнэлгээ.....	6
1.3. Жижиг, дунд бизнесийн таатай орчин бурдуулэх бодлого .....	8
<b>2. ЖДУ-ИЙН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ЗОРИЛГО БА АРГАЧЛАЛ.....</b>	<b>10</b>
2.1. Түүвэр судалгааны зорилго, ач холбогдол.....	10
2.2. Хэлцлийн зардал ба түүнийг хэмжих нь .....	10
2.3. Судалгааны түүвэрлэлт ба асуулга .....	11
2.4. Судалгааны түүврийн үндсэн мэдээлэл .....	11
<b>3. ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН .....</b>	<b>13</b>
3.1. Албан ёсны буртгэлтэй холбоотой хэлцлийн зардал .....	13
3.2. Тусгай зөвшөөрөл ба мэргэжлийн хяналттай холбоотой хэлцлийн зардал .....	16
3.2.1. Тусгай зөвшөөрөл авахтай холбоотой хэлцлийн зардал .....	17
3.2.2. Мэргэжлийн хяналттай холбоотой хэлцлийн зардал .....	19
3.3. Гэрээний хэрэгжилттэй холбоотой хэлцлийн зардал .....	21
3.4. Төрийн байгууллагатай харилцахтай холбоотой хэлцлийн зардал .....	23
<b>4. ТАТВАР БА ГААЛЬТАЙ ХОЛБООТОЙ ХЭЛЦЛИЙН ЗАРДАЛ.....</b>	<b>26</b>
4.1. Татвартай холбоотой хэлцлийн зардал .....	26
4.2. Гааль, гадаад худалдааны уйл ажиллагаатай холбоотой хэлцлийн зардал .....	28
<b>5. ДЭД БУТЭЦ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЧИНТОЙ ХОЛБООТОЙ ХЭЛЦЛИЙН     ЗАРДАЛ.....</b>	<b>30</b>
5.1. Дэд бутэцтэй холбоотой хэлцлийн зардал.....	30
5.2. Санхүүгийн байгууллагатай харилцахтай холбоотой хэлцлийн зардал	33
<b>6. НИЙТ ХЭЛЦЛИЙН ЗАРДАЛ.....</b>	<b>36</b>
<b>7. ДҮГНЭЛТ .....</b>	<b>38</b>
<b>8. АШИГЛАСАН МАТЕРИАЛ .....</b>	<b>39</b>

## **ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ**

ААН	– Аж ахуйн нэгж
ДНБ	– Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДУ	– Жижиг, дунд үйлдвэр
МҮХАҮТ	– Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
МХГ	– Мэргэжлийн хяналтын газар
НДШ	– Нийгмийн даатгалын шимтгэл
НОАТ	– Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОӨҮБЕГ	– Оюуны өмч, улсын бүртгэлийн өрөнхий газар
ХАА	– Хөдөө аж ахуй

## ОРШИЛ

Дэлхий даяар тэр дундаа Монгол Улсад жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ) болон бичил бизнес эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, ажиллах хүчнийг ажлын байраар хангах, ядуурлыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэж байна. (UNDP, 1999; Дэлхийн Банк, 2012) Манай улсад ЖДҮ-ийн салбарыг хөгжүүлэхэд санхүүгийн хүртээмж хамгийн бэрхшээлтэй асуудал байдаг. Гэхдээ сүүлийн жилүүдэд хэрэгжүүлсэн бодлогын үр дунд ЖДҮ-ийн санхүүгийн хүртээмж ихээхэн дээшилжээ. Тухайлбал, 2009 оны аж ахуйн нэгжийн судалгаагаар дунд аж ахуйн нэгжүүдийн 27,2 хувь нь, жижиг аж ахуйн нэгжүүдийн 32,8 хувь нь санхүүгийн хүртээмжийг бизнест тулгарч буй хамгийн том бэрхшээл гэж үзэж байсан бол 2013 онд энэ тоо 13,0 ба 24,8 болж тус тус буурсан байна. (World Bank, 2013)

Гэвч бусад бэрхшээл, тэр дундаа төрийн институцтай холбоотой асуудал бизнес эрхлэхэд хүндрэл учруулсаар байна. Дэлхийн Банкны дээрх судалгаагаар дунд аж ахуйн нэгжүүдийн 18,1 хувь нь улс төрийн тогтвортгүй байдлыг, 14,8 хувь нь авилгыг, жижиг аж ахуйн нэгжүүдийн 16,5 хувь нь татварын түвшинг, 13,7 хувь нь бизнес эрхлэх зөвшөөрөл, лицензийг хамгийн бэрхшээлтэй асуудлын тоонд оруулж нэрлэжээ. Эдгээр асуудлыг дотоодын болон олон улсын байгууллагуудын бусад судалгаа ч онцолдог. Жишээлбэл, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимиын 2004 оны судалгаагаар жижиг бизнес эрхлэгчдийн 30-аас дээш хувь нь бизнесээ эрхлэхэд хүнд суртал, хяналт шалгалтын байцаагчдын дарамт зэргийг хамгийн их хүндрэл учруулдаг гэж дурдаж байсан (MYXAYT, 2004) бол Монголбанкны 2011 оны судалгаагаар ЖДҮ эрхлэгчдийн тал хувь нь тухайн үеийн эдийн засгийн өндөр өсөлт бизнест нь нөлөөлөөгүй, эсвэл сөргөөр нөлөөлсөн гэж үзээд бизнес эрхлэхэд нь хээл хахууль, улс төрийн тогтвортгүй байдал зэрэг нийгмийн орчны асуудал, төрийн байгууллагын үйлчилгээ, зам тээврийн хөгжил зэрэг бизнесийн орчны асуудал хамгийн их тулгамдаж байгааг дурджээ. (Монголбанк, 2011) Харин Дэлхийн Эдийн Засгийн Форумын 2014-2015 оны өрсөлдөх чадварын тайланд Монголд бизнес эрхлэх хамгийн бэрхшээлтэй асуудлуудаар төрийн хүнд суртал, гадаад валютын муу зохицуулалт, боловсролтой ажиллах хүчний тааруу олдоц, инфляци, улс төрийн тогтвортгүй байдал, авилгыг нэрлэсэн байна. (WEF, 2014) Дэлхийн Банкны 2014 оны “Бизнес эрхлэхүй” судалгаагаар цахилгаанд холбогдох, барилгын зөвшөөрөл авах, экспорт импортын бичиг баримт бүрдүүлэх, бизнесээ хаах зэрэг үйл ажиллагаагаар Монгол Улс 189 орноос 107-оос хойш байр эзэлж байна. (World Bank Group, 2014)

Үүнтэй холбоотойгоор ЖДҮ хөгжих, өсөж томрох таатай орчинг бүрдүүлэх стратегийг тодорхойлох, ялангуяа, уг салбарыг дэмжих хөшүүргийг оновчтой тодорхойлох хэрэгтэй байна. Энэ нь Монголын ЖДҮ-ийн салбарын онцлогийг илүү нарийвчлан судлах шаардлагатай гэсэн үг. Жишээлбэл, Дэлхийн Банкны судалгаанаас үзэхэд дэлхий дахинд жижиг бөгөөд шинэ компаниуд бусад аж ахуйн нэгжтэй харьцуулахад илүү их ажлын байр бий болгодог ажээ. (Ayyagari, Demirguc-Kunt, & Maksimovic, 2011) Харин манай улсад ямар чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг, ямар хэмжээтэй ЖДҮ илүү их ажлын байр бий болгож, илүү хурдан өсдөг, улирлын хэлбэлзэл хэрхэн нөлөөлдөг, амьдралын мөчлөг хэрхэн үргэлжилдэг, бизнес эрхлэгчийн хүйсээс хамаарч ямар ялгаа гардаг, бүтээмжийн өсөлт хэр ялгаатай байdag гэх мэт онцлогийн талаарх нарийн судалгаа хийгдээгүй байна.

Үүнээс гадна манай улсын хувьд ЖДҮ-ийн салбарын зардлын томоохон хувийг эзэлдэг хувийн хэвшил ба төрийн хоорондын харилцаанаас үүсэх хэлцлийн зардлыг микро судалгаанд үндэслэн тооцох нь чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Жишээ нь, Монголын хувийн компаниуд Засгийн газартай хийх гэрээгээ баталгаажуулахын тулд гэрээний үнийн дүнгийн 1,3 хувьтай тэнцэх бэлэг өгдөг, цахилгаан тасарснаас болж борлуулалтын 0,7 хувьтай тэнцэх алдагдал хүлээдэг, төрийн байгууллагаас тавьсан шаардлагуудыг биелүүлэхийн тулд компанийн удирдлагууд ажлын цагийнхaa 20 хувийг зарцуулдаг ажээ. (World Bank, 2013)

Энэхүү судалгаагаар бид ЖДҮ-ийн салбарт тулгардаг хэлцлийн зардлыг нарийвчлан судлах зорилго дэвшүүлж байгаа бөгөөд үүний тулд эхлээд ЖДҮ-ийн институцийн орчны талаарх онолын үзэл баримтлалуудыг тоймлон судлав. Тайлангийн 2-р бүлэгт энэхүү судалгааны үндсэн хэсэг болох ЖДҮ-ийн түүвэр судалгааны аргазүй, хэлцлийн зардлыг хэмжих аргачлалын талаар авч үзсэн бол тайлангийн дараагийн бүлгүүдэд судалгааны үндсэн үр дүнг дэлгэрэнгүй танилцууллаа. Энэ хүрээнд бид ЖДҮ эрхлэгч 1541 аж ахуйн нэгжээс түүвэр судалгаа авч, анхдагч мэдээлэл цуглуулж, тэдэнд учрах зах зээлийн бус хэлцлийн зардлыг бизнесийн үйл ажиллагааны үе шат бүрээр нарийвчлан үнэлэх тоон судалгаа хийлээ.

# **1. ЖДҮ-ИЙН ИНСТИТУЦИЙН ОРЧИН, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ**

## **1.1. Институцийн эдийн засаг**

Бизнесийн таатай орчны ач холбогдлын талаарх суурь онол нь институцийн шинэ экономикс, тэр дундаа хэлцлийн зардлын экономикс юм. Нобелийн шагналт эдийн засагч Д.Норт институцийг “хүмүүс хоорондын харилцааг хашиж хязгаарлахын тулд зохиосон дүрэм журам” гэж тодорхойлсон байдаг. (North, 1990) Энэ “тоглоомын дүрэм” нь бизнесийг өсөж хөгжихөд урамшил, хөшүүрэг болдог. Институцийг сахиулж буй хэлбэрээр нь албан ба албан бус институц гэж ангилдаг. Албан институц нь хуульчилсан дүрэм журам хэлбэртэй, түүнийг зөрчвэл албан ёсны хариуцлага хүлээлгэх механизмтай байдаг бол албан бус институц нь нийгэмд мөрдөгдөх хэм хэмжээ, үнэлэмж хэлбэртэй бөгөөд шүүмжлэх, жигших зэргээр уг хэм хэмжээг дагаж мөрдөхийг шахдаг.

Улс орны эдийн засгийн хөгжил буурай байх үед мэдээлэл боловсруулах, өмчлөх эрхийг хэрэгжүүлэх, гэрээг мөрдүүлэхэд гарах зардлыг нийтлэг шашин соёл, нутаг нуга, сургуулийн наиз нөхөд, танил гэх мэт нийгмийн хэлхээ холбоо, итгэлцэлд тулгууруласан албан бус институц бууруулж байдаг. Гэхдээ энэ нь бизнесийн үйл ажиллагаа төрөлжиж нарийсах үед хангалттай дэмжлэг болж чаддаггүй. Улс орон хөгжихийн хэрээр зах зээлд оролцогчдын тоо, цар хүрээ нэмэгдэж, хэлцлүүд нарийн төвөгтэй болж албан институц шаардлагатай болдог. Албан ба албан бус институцууд бие биенээ нөхөн гүйцээж байх ёстой. Эдгээр институц хамтдаа байвал хэлцлийн зардлыг илүү их хэмжээгээр бууруулна. (Нарантуяа & бусад, 2009) Харин итгэлцлийн түвшин багатай нийгэмд хүчтэй институц байхгүй бол бизнесийн хэлцлийн зардал маш өндөр болж, шинэ бизнес эхлүүлэх, эсвэл байгаа бизнесээ томруулах боломж эрс буурна. Ялангуяа ЖДҮ эрхлэгчид хөрөнгө хязгаарлагдмал учраас хэлцлийн зардлыг бууруулах хууль ёсны арга хэмжээ авч чаддаггүй, итгэлцэлд тулгуурулахыг чухалчилдаг. Гэтэл итгэж болох хүн цөөтэй үед хэлцлийн зардал маш өндөр гарч болзошгүй юм.

Албан институцийн хувьд өмчлөх эрх нь ЖДҮ-ийн хөрөнгө, ашиг орлогыг төр завшихаас хамгаалдаг бол гэрээний хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа нь ЖДҮ-ийн хөрөнгө, ашиг орлогыг бусад иргэд завшихаас хамгаалах ёстой. (Acemoglu & Johnson, 2005) Үүнээс гадна авилгыг хазаарлах, хэт өндөр татварыг бууруулах, гэрээний олон улсын стандартыг нэвтрүүлэх, тэдгээр стандартыг жигд хэрэгжүүлэх нь ЖДҮ-ийн хөрөнгө, ашиг орлогыг янз бүрийн хэлбэрээр завшихаас сэргийлдэг.

## **1.2. Бизнесийн орчны үнэлгээ**

Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх түвшинд очих эсэх нь ЖДҮ эрхлэгчийн бизнес эрхлэх ур чадвараас хамаардаг бөгөөд бизнес эрхлэх орчин өрсөлдөөнд чухал нөлөөтэй байдаг. Ерөнхийдөө аливаа улсын ЖДҮ-ийн секторт бизнес эрхлэх орчны дараах хүчин зүйлс нөлөөлдөг. Үүнд:

- ✓ Макро болон микро түвшний бодлого,
- ✓ Үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн хүрэлцээ,
- ✓ Бизнес эрхлэх соёл,
- ✓ Технологи,
- ✓ Зохицуулалтын цар хүрээ,
- ✓ Дэд бүтэц.

Олон улсын байгууллагууд улс орнуудын бизнес эрхлэх орчинд анхаарал хандуулж, бизнесийн орчны судалгааг тогтмол хийдэг. Тухайлбал, “Бизнес эрхлэхүй” (Дэлхийн Банк), “Эдийн засгийн эрх чөлөөний индекс” (Херитеиж Сан, Фрейзер Институц), “Дэлхийн

өрсөлдөх чадварын индекс” (Дэлхийн Эдийн Засгийн Форум), “Авлигын индекс” (Транспэрэнс Интернэшнел) зэрэг гол судалгааг энд дурдаж болно.

Дэлхийн Банкны жил бүр хийдэг “Бизнес эрхлэхүй” судалгааг дэлхийн улсуудын (хамгийн сүүлд 183 улсыг хамарсан) эдийн засаг, бизнесийн орчны талаарх өргөн хүрээг хамарсан судалгаа гэж үздэг. Уг судалгаагаар дараах 10 бүлэг үзүүлэлтийг ашиглан тухайн улсад бизнес эрхлэхэд хэр хялбар байгааг үнэлдэг. Үүнд:

- ✓ Бизнесээ эхлэх,
- ✓ Барилгын зөвшөөрөл авах,
- ✓ Цахилгаанд холбогдох,
- ✓ Өмчөө бүртгүүлэх,
- ✓ Зээл авах,
- ✓ Хөрөнгө оруулагчийг хамгаалах,
- ✓ Татвар төлөх,
- ✓ Гадаад худалдаа хийх,
- ✓ Гэрээний хэрэгжилтийг хангах,
- ✓ Төлбөрийн чадваргүй байдлыг шийдвэрлэх.

Энэ судалгаа тухайн эдийн засгийн тогтвортой байдал болон сул талыг онцлоход нэн чухал ач холбогдолтой. 2014 онд хийсэн “Бизнес эрхлэхүй” судалгааны дүнгээр Монгол Улс 189 улсаас 72-р байранд орж, өмнөх жилийнхээс 2 байраар ухарсан байна. Үүнд нөлөөлсөн хамгийн гол хүчин зүйл бол бизнесээ эрхлэхэд илүү хүндрэлтэй болж өмнөх жилийнхээс 4 байраар ухарсан, төлбөрийн чадваргүй байдлыг шийдвэрлэхэд илүү хүндрэлтэй болж өмнөх жилийнхээс 3 байраар ухарсан явдал юм. (World Bank, 2014)

Фрейзер Институцийн 20 гаруй жил тооцож буй дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний индекс хамгийн сүүлийн байдлаар 143 улсыг хамарч, эдийн засгийн эрх чөлөөг 42 дэд үзүүлэлт бүхий 5 бүлэг үзүүлэлтээр хэмждэг. Үүнд:

- ✓ Засгийн газрын хэмжээ,
- ✓ Хуулийн бүтэц ба өмчлөх эрхийн хамгаалалт,
- ✓ Эрүүл мэнгэ хүртэх боломж,
- ✓ Олон улсын худалдаанд оролцох эрх чөлөө,
- ✓ Зээл, хөдөлмөр, бизнесийн зохицуулалт.

2014 оны Фрейзер Институцийн тайланд Монгол Улс 6,98 оноо авч (2012 оны мэдээлэлд үндэслэн тооцсон), нийт 152 улсаас 77-р байранд жагссанаар өмнөхөөсөө 11 байраар ухарсан байна. Эдийн засгийн эрх чөлөөг тооцдог 5 талбар бүрд индексийн утга буурч, эрх чөлөө хумигдсан нь үүнд нөлөөлжээ. (Gwartney, Lawson, & Norton, 2014)

Дэлхийн Эдийн Засгийн Форум жил бүр “Дэлхийн өрсөлдөх чадварын индекс”-ийг тооцдог. Тус форум эдийн засгийн өрсөлдөх чадварыг тодорхойлох 12 тулгуур үзүүлэлтийг авч үздэг. Үүнд:

- ✓ Институц,
- ✓ Дэд бүтэц,
- ✓ Макро эдийн засгийн орчин,
- ✓ Эрүүл мэнд ба анхан шатны боловсрол,
- ✓ Дээд боловсрол ба мэргэжлийн сургалт,
- ✓ Бараа, үйлчилгээний зах зээлийн үр ашиг,
- ✓ Хөдөлмөрийн зах зээлийн үр ашиг,
- ✓ Санхүүгийн зах зээлийн хөгжил,
- ✓ Технологийн бэлэн байдал,
- ✓ Зах зээлийн багтаамж,
- ✓ Бизнесийн боловсронгуй байдал,

- ✓ И nnovaci.

Эдгээр үзүүлэлт хоорондоо тодорхой хамааралтай бөгөөд нэгнийх нь давуу ба сул тал бусдадаа нөлөөлдөг. “Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан 2014-2015”-д Монгол Улс 3,83 оноо авч 144 улсаас 98-р байранд орсон байна. Энэ нь өмнөх тайлангийн үр дүнтэй (2013-2014 оны тайланд 3,7 оноо авч 148 улсаас 107-р байранд орсон) харьцуулахад сайжирсан үр дүн юм. (Schwab & Sala-i-Martín, 2014)

### **1.3. Жижиг, дунд бизнесийн таатай орчин бүрдүүлэх бодлого**

Хөгжиж буй болон хөгжингүй орнуудын эдийн засгийн хөгжил дэх ЖДҮ-ийн хөгжлийн ач холбогдол өнгөрсөн хугацаанд хангалттай хүлээн зөвшөөрөгдсөнийг олон судалгаанаас харж болно. ЖДҮ-ийн өсөлтийг дэмжихийн тулд соёл, үйл хөдлөл, нийгмийн олон хүчин зүйлийг авч үзэх шаардлагатай болдог. ЖДҮ-ийн хөгжлийн ерөнхий зорилгыг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- ✓ Шинээр ажлын байр бий болгох,
- ✓ ЖДҮ-ийн гүйцэтгэл, өрсөлдөх чадварыг сайжруулах,
- ✓ Нийт эдийн засагт оруулах хувь нэмэр, оролцоог нэмэгдүүлэх.

Эдгээр зорилгод хүрэхэд даван туулах шаардлагатай олон саад бэрхшээл тохиолддог. Тухайлбал, бизнес эрхлэх орчин муу (хүнд суртал, татварын дарамт их, өмчлөх эрхийн хамгаалалт сул), суурь дэд бүтэц хүрэлцээгүй, санхүүжилт авах боломж хомс, технологийн хүчин чадал муу, дотоодын ба дэлхийн зах зээл дээрх өрсөлдөөний дарамт их байdag нь ЖДҮ-ийн хөгжлийг ихээхэн хязгаарладаг.

Капитал, удирдлагын ур чадвар, техникийн хүчин чадал, зах зээлийн мэдлэг зэргээс үүсэх зарим асуудлыг ЖДҮ эрхлэгчид өөрсдөө зохицуулах боломжтой. Жишээлбэл, удирдлагын ба маркетингийн ур чадвар муу байх, түүхий эд материал, нөөцийг дутуу ашиглах, эргэлтийн хөрөнгө ба хүний нөөц хомсдох, техник болон үйл ажиллагааны зохицол алдагдах зэрэг дотоод асуудлыг бизнес эрхлэгчид өөрсдөө ямар нэг байдлаар шийдвэрлэх боломж бий. Гэхдээ бизнес эрхлэгчдийн өөрсдөө зохицуулж, хянах боломжгүй олон асуудал байдаг. Олон улсын байгууллагууд буурай хөгжилтэй орнууд дахь ЖДҮ-ийн салбарын эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхийн тулд дараах талбаруудад анхаарлаа хандуулах болжээ. Үүнд:

- ✓ Бизнес эрхлэх орчин,
- ✓ Бизнес эрхлэх соёлын дэмжлэг,
- ✓ Бизнесийн санхүүжилт,
- ✓ Бизнес хөгжлийн үйлчилгээ,
- ✓ Шинэчлэл, технологийн хөгжил ба нэвтрүүлэлт,
- ✓ Зах зээлд нэвтрэх боломж.

ЖДҮ хөгжих таатай орчин бүрдүүлэхэд төрийн бодлого, дэмжих дэд бүтэц амин чухал ач холбогдолтой. (World Bank, 2011) Тухайлбал, ил тод, зардал чирэгдэл багатай бодлого зохицуулалтын орчин нь аж ахуйн нэгж байгуулах, үйл ажиллагаагаа эрхлэх, хүн хүч, санхүүгийн нөөц болон зах зээлээ олох, бүтэлгүйтсэн тохиолдолд зах зээлээс гарах зэрэгт маш чухал үүрэгтэй. Бизнесийн таатай орчин гэдэгт үндэсний түвшинд бодлого, засаг захиргааны шийдвэр, дүрэм журам, нийтийн дэд бүтцийн хөгжил зэргийг багтаадаг бол олон улсын түвшинд гэрээ конвенц, зах зээлийн стандартуудыг багтааж ойлгодог. Мөн албан бус хүчин зүйлс болох нийгмийн хэм хэмжээ, бизнесийн ёс зүй зэрэг институц бизнесийн орчин бүрдэхэд чухал нөлөөтэй.

Бизнесийн эрүүл орчин бүрдсэнээр бизнес шинээр эхлэх, тэсч үлдэх, өсөх суурь тавигдана. Энд бизнесийн эрүүл орчин гэдэгт дараах нөхцөлийг хамруулдаг. (Abe, Troilo, Juneja, & Narain, 2012) Үүнд:

- ✓ Бизнесийн талбар ил тод, нээлттэй, шударга, өрсөлдөөнтэй байх,
- ✓ Дагаж мөрдөх хууль нь бүх бизнес эрхлэгчдэд ойлгомжтой, хараат бус байх,
- ✓ Бизнес эхлэх, дуусгахад хялбар байх,
- ✓ Хуулийн зохицуулалт тэгш үйлчлэх, тогтвортой байх.

Бизнесийн таатай орчин хувийн хэвшил ба төрийн секторын аль алины зардлыг бууруулж, бүтээмжийг нэмэгдүүлж, өсөлтийг дэмждэг. Бизнесийн таатай орчин ЖДҮ-үүдэд тулгардаг захиргааны элдэв зардал чирэгдлийг багасгаад зогсохгүй маркетинг, менежмент зэрэг бизнесийнхээ үндсэн үйл ажиллагаанд төвлөрч ажиллах боломж олгодог. Засгийн газрын зүгээс хувийн хэвшлийг зохицуулах, хянахад бага нөөц зарцуулж, үүнээс чөлөөлөгдхөн нөөцөөр дэд бүтэц, бизнесийн хөгжлийн үйлчилгээнд хөрөнгө оруулах боломжтой болно.

ЖДҮ-ийг дэмжих бодлого гурван гол үндэслэлд тулгуурладаг. Нэгдүгээрт, ЖДҮ-ийн хөгжил өрсөлдөөнийг нэмэгдүүлэн, бизнес эрхлэх ур чадварыг урамшуулж, улмаар нийт эдийн засгийн үр ашигт байдал, инноваци, нийт бүтээмжийн өсөлтөд эерэг дам нөлөөг үзүүлдэг. Хоёрдугаарт, ЖДҮ-үүд том үйлдвэрүүдтэй харьцуулахад илүү бүтээмжтэй байдаг боловч санхүүгийн зах зээл болон бусад институцийн сүл хөгжил ЖДҮ-ийн хөгжлийг хойш татдаг. Иймд ЖДҮ-ийн санхүүжилт болон институцийг сайжруулах, засгийн газрын санхүүгийн шууд дэмжлэг маш чухал. Гуравдугаарт, ЖДҮ хөдөлмөрийг илүү эрчимтэй ашигладаг учраас ЖДҮ-ийн өсөлт нь том үйлдвэрлэгчийн өсөлтөөс илүүтэй ажил эрхлэлтийг дэмждэг. Иймд ЖДҮ-ийн салбарт татаас өгөх замаар ядуурлыг бууруулах боломжтой.

Гэхдээ ЖДҮ-т татаас өгөх замаар дэмжих бодлогын үр нөлөөнд зарим судлаач эргэлздэг. Нэгдүгээрт, тэд том үйлдвэрлэгчдийн давуу талыг онцолж, ЖДҮ-ийг дэмжих бодлогын урьдач нөхцөлүүдийг шүүмжилдэг. Тухайлбал, том үйлдвэрүүд өргөжилтийн хэмнэлт гаргах (олноор нь үйлдвэрлэж нэгжийн өргтгийг бууруулах), бүтээмжид эерэгээр нөлөөлөхүйц судалгаа хөгжлийн тогтмол зардлыг гаргах чадавхтай байдаг. Түүнчлэн том үйлдвэрүүд жижиг үйлдвэртэй харьцуулахад илүү тогтвортой, өндөр чанартай ажлын байрыг бий болгож, ядуурлыг бууруулахад эерэгээр нөлөөлдөг. Хоёрдугаарт, ЖДҮ-ийг дэмжих бодлогын урьдач нөхцөлүүд үндэслэл муутай. Том үйлдвэртэй харьцуулахад ЖДҮ ажлын байрыг илүү бий болгодоггүй, мөн үйлдвэрлэлдээ хөдөлмөрийг эрчимтэй ашигладаг гэдэгт хангалттай үндэслэл байхгүй гэж зарим судлаач дүгнэсэн байдаг. (Little, Mazumdar, & Page, 1987) Үүнээс гадна санхүү болон хуулийн институцийн буурай хөгжил ЖДҮ-т чөдөр тушаа болдог нь бодлогын үр дүнг сааруулдаг. Гуравдугаарт, үйлдвэрлэгчийн хэмжээг эдийн засгийн өсөлтийг тодорхойлогч экзоген хүчин зүйлээр авч үзэх үндэслэл бага. Байгалийн нөөцийн элбэг байдал, технологи, бодлого, институцүүд тухайн улсын салбарын бүтэц, үйлдвэрлэгчийн оновчтой хэмжээг тодорхойлох хүчин зүйл болдог. Жишээлбэл, зарим улс том үйлдвэрлэгч илүү үр ашигтай үйлдвэрлэх бүтээгдэхүүний үйлдвэрлэлд харьцангуй давуу талтай байхад бусад нь жижиг үйлдвэрлэгч хамгийн хэмнэлтэй үйлдвэрлэх бүтээгдэхүүний үйлдвэрлэлд харьцангуй давуу талтай байж болно. Энэ бүх шалтгаанаар зарим судлаач ЖДҮ-ийн гүйцэтгэх үүргийг онцлон авч үзэхийн оронд том, жижиг бүх үйлдвэрлэгчийн өмнө тулгарах бизнесийн орчны ач холбогдолд анхаарлаа хандуулах хэрэгтэй гэж үздэг. Тухайлбал, зах зээл рүү орох, гарахад учрах саад хориг бага байх, өмчлөх эрх сайн хамгаалагдсан байх, үр ашигтай гэрээний хэрэгжилт зэрэг нь өрсөлдөөн, зах зээлийн арилжаанд нөлөөлөх бизнесийн орчныг тодорхойлдог.

## **2. ЖДУ-ИЙН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ЗОРИЛГО БА АРГАЧЛАЛ**

### **2.1. Түүвэр судалгааны зорилго, ач холбогдол**

Уг түүвэр судалгаагаар манай улсын ЖДУ эрхлэгчдэд тулгардаг хэлцлийн зардлыг бизнесийн үйл ажиллагааны үе шат бүрээр нарийвчлан хэмжиж, улмаар бизнес эрхлэх орчинг сайжруулахад нэн тэргүүнд анхаарах хүчин зүйлсийг тодруулах зорилготой.

Энэ судалгаа Монголын ЖДУ-ийн талаар урьд хийгдсэн судалгаануудтай харьцуулахад дараах ач холбогдолтой гэж үзэж байна.

- ✓ Манай улсад ЖДУ эрхлэгчдэд тулгарч буй хэлцлийн зардлын томоохон хэсгийг микро түвшний тоон мэдээллээс тооцож, борлуулалтын орлоготой нь харьцуулах замаар хэр их дарамт учруулж байгааг тодорхойлно.
- ✓ ЖДУ эрхлэгчид төрийн байгууллагатай харилцах суваг бүр дээр гарах хэлцлийн зардлыг шууд, шууд бус, албан бус зардлаар ангилан үнэлнэ.
- ✓ Хувийн хэвшил хоорондоо болон санхүүгийн байгууллагатай харилцахад үүсдэг хэлцлийн зардлыг мөн нарийвчлан үнэлнэ.
- ✓ Хэлцлийн зардал нь ЖДУ-ийн хэмжээ, үйл ажиллагааны чиглэл, байршил зэрэг шинж чанаруудаар хэр ялгаатай байгааг харьцуулна.

### **2.2. Хэлцлийн зардал ба түүнийг хэмжих нь**

Хэлцлийн зардал гэдэг нь бизнесийн харилцаа, хамтын ажиллагааны явцад үүсдэг зардал бөгөөд зарим талаар эдийн засагт үр ашиггүй “үрэлт”-ийг бий болгодог. Элдэв хүнд суртал багатай, итгэлцэл сайтай нийгэмд аж ахуйн нэгжүүдэд учрах үр ашиггүй хэлцлийн зардал бага байдаг. Энэ хэрээр бизнесийн орчин таатай болж, эдийн засгийн хөгжлийн нэг чухал нөхцөл бүрддэг. Харин бизнес эрхлэгч бизнесээ хууль ёсоор бүртгүүлэх, тусгай зөвшөөрөл авах, татвар төлөх, санхүүжилт олох бүрдээ нүсэр хүнд суртал, ярвигтай дүрэм журамтай тулгардаг бол үйл ажиллагаанд нь saatал, нэмэлт зардал учирна. Уг үйл ажиллагаанд гарах хураамж, төлбөр, татвар зэрэг шууд зардлаас гадна зарцуулсан цаг хугацааны алдагдсан боломжийн зардлыг бас тооцох хэрэгтэй. Энэ зардлаас зайлсхийхийн тулд бизнес эрхлэгчид албан ёсны зуучлагч, зөвлөхөд хандах, танил талаараа дамжуулан шийдүүлэх, эсвэл холбогдох албан тушаалтанд бэлэг сэлт, авилга өгөх зэрэг арга хэмжээ авч болно. Үүнд гарч буй зардлуудыг ч бас харгалзах ёстой. Хэлцлийн зардал хэт их бол бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа хумих, эсвэл албан бус салбарт шилжих сонголт хийдэг. Энэ нь тэднийг цаашид өсөж, ажлын байр нэмэгдүүлэх боломжийг нь хязгаарладаг.

Хэлцлийн зардал нь зөвхөн бизнес эрхлэгчдэд тулгараах зардал биш юм. Нүсэр хүнд суртлыг ажиллуулах, ярвигтай дүрэм журмыг дагаж мөрдүүлэх нь төрийн байгууллагаас ч бас ихээхэн зардал шаардана.

Иймээс захиргааны саад тотгорыг багасгах, хялбарчлах стратеги боловсруулахын тулд бизнесийн харилцааны төрөл бүрийн шууд ба шууд бус хэлцлийн зардлыг харгалзаж үзэх шаардлагатай. Хэлцлийн зардлын гол бүрэлдэхүүн хэсгийг олж илрүүлэн бууруулснаар улс орны бизнесийн орчныг сайжруулж, улмаар бүтээмж ба өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

Гэхдээ эмпирик судалгаагаар хэлцлийн зардлыг хэмжихэд маш төвөгтэй байдаг. Тухайлбал, хэлцлийн зардлын тодорхойлолтоос хамаараад хэлцлийн зардалд зар сурталчилгаа, захиргаа удирдлага, санхүү бүртгэл, судалгаа хөгжил, төрийн байгууллага болон олон нийттэй харилцах гэх мэт бизнесийн янз бүрийн хүрээнд гарах зардлыг хамруулдаг. Ялангуяа ЖДУ эрхлэгчид санхүүгийн тайландаа эдгээр зардлыг нарийвчилж бүртгээгүй байх тохиолдол их тул үйлдвэрлэлийн, тээврийн гэх мэт зардлаас ялгаж салгахад төвөгтэй.

Мөн уг зардлын хэмжээг ихэвчлэн хувь хүний субъектив үнэлэмжээр тодорхойлдог, хэлцлийн зардлыг нарийн хэмжих нь өөрөө зардал их шаарддаг зэргийг харгалзах хэрэгтэй.

Олон улсын түвшинд хэлцлийн зардлыг хэмжих эмпирик судалгаанууд маш олноор хийгддэг. Жишээлбэл, Нобелийн шагналт Оливер Уильямсон тэргүүтэй судлаачид хэлцлийн зардлыг байгууллагын болон гэрээний хэлбэрээс хамааруулан эрэмбэлэх, тухайн үйл ажиллагааны тодорхойгүй байдал, давтамж, хөрөнгийн зориулалтын нарийвчлал нь хэлцлийн зардалд хэрхэн нөлөөлж буйг тогтоосон олон судалгаа хийсэн байдаг. Харин Жон Уоллис, Даглас Норт тэргүүтэй судлаачид “хэлцлийн салбар”-ын хэмжээг тогтоо замаар тухайн эдийн засаг дахь хэлцлийн зардлын нийт хэмжээг тооцох судалгааг хийсэн байдаг. Жишээлбэл, Манай улсад Нээлттэй нийгэм хүрээлэнгийн гүйцэтгэсэн “Эдийн засгийн эрх чөлөөний тайлан-2006” судалгаанд эдийн засаг дахь “хэлцлийн салбарын” хэмжээг тухайн үед ДНБ-ий 27 хувь гэж тооцсон байдаг. Мөн эдийн засгийн аль нэг салбар дахь хэлцлийн зардлын хэмжээг тооцсон судалгаануудыг энэ ангилалд хамааруулж болно.

Гурав дахь чиглэлийн судалгаанд Эрнандо де Сотогийн эхлүүлсэн “Зах зээлийн бус хэлцлийн зардал”-ын судалгаа орно. Зах зээлийн бус хэлцлийн зардалд бизнесийн зөвшөөрөл авах, элдэв хүнд суртлыг давахад зарцуулж буй хүн хүч, цаг хугацаа, албан тушаалтнуудад өгөх авилга зэргийг багтаана. Хөгжиж буй орнуудад энэхүү зах зээлийн бус хэлцлийн зардлын хэмжээ маш их байдаг. Бидний энэ судалгааны зорилго ЖДУ бизнес эрхлэгчид төрийн байгууллагатай харилцахад тулгардаг зах зээлийн бус хэлцлийн зардлыг хэмжихэд оршино.

### **2.3. Судалгааны түүвэрлэлт ба асуулга**

Судалгааны түүврийг албан ёсны бүртгэлтэй аж ахуйн нэгжээс сонголоо. Албан бус салбарт ажилладаг аж ахуйн нэгжүүд эдийн засгийн үйл ажиллагаанд томоохон хувь эзэлдэг боловч бүтээмж харьцангуй бага бөгөөд нийт эдийн засгийн өсөлт, хөгжил нь албан секторын өндөр бүтээмжтэй аж ахуйн нэгжүүдийн өсөлтөөс бүрэн хамаардаг. (La Porta & Shleifer, 2008) Нөгөө талаас Дэлхийн Банкны судалгаагаар 2006 онд Монголын эдийн засаг дахь албан бус секторын эзлэх хувь 16,8 хувь, Үндэсний статистикийн хорооны тооцоогоор 2010 онд 13,7 хувь байсан нь харьцангуй бага үзүүлэлт юм. (Schneider, Buehn, & Montenegro, 2010; YCX, 2013)

Монгол Улсад бизнес регистрийн санд бүртгэгдсэн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж 2014, 2015 онуудад харгалзан 59'843, 64'301 байжээ. (YCX, 2015) Уг эх олонлогийг 95 хувийн итгэх түвшинд,  $\pm 2,5$  хувь итгэх завсартай төлөөлөх түүврийн хэмжээ  $n = 1500$  бөгөөд бид 1541 аж ахуйн мэдээллийг цуглууллаа.

Түүвэрт хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн удирдлагаас асуулга анкетын аргаар мэдээлэл цуглуулж, мэдээллийн санг бүрдүүлсний дараа STATA 14.2 программ хангамж ашиглан боловсруулж, шинжилгээ хийв. Судалгааны үндсэн хэрэглэгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдээс авах асуулга юм. Асуулга нь дараах хүрээг хамарсан болно. Үүнд:

- ✓ Аж ахуйн нэгжийн үндсэн мэдээлэл Үйл ажиллагааны салбар, ажилчдын тоо, байршил, борлуулалтын орлого, байгуулагдсан он, салбар нэгжийн тоо гэх мэт суурь мэдээлэл,
- ✓ Хэлцлийн зардал Бүртгэл, зөвшөөрөл, гааль, татвар, мэргэжлийн хяналт, дэд бүтэц, гэрээний хэрэгжилт гэх мэт хүрээнд үүсэх хэлцлийн зардалтай холбоотой мэдээлэл.


### **2.4. Судалгааны түүврийн үндсэн мэдээлэл**

Санал асуулгад нийт 1541 ЖДУ эрхлэгчид хамрагдсан бөгөөд үүний 752 нь 2015 онд, 789 нь 2016 онд хамрагдсан болно. Энэхүү судалгаанд голчлон хэлцлийн зардал буюу төрийн

үйлчилгээтэй холбоотой тоон бус зардлыг хэмжихийг зорьж байгаа тул хүн амын төвлөрөл ихтэй нийслэл болон аймгуудын ЖДҮ эрхлэгчдээс судалгааг авав. Түүвэрт 87,1 хувь нь Улаанбаатар хотоос, 6,7 хувь нь Орхон аймгаас, 6,2 хувь нь Дархан-Уул аймгаас оролцлов.

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчийн дийлэнх буюу 64,9 хувийг худалдаа үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй өөрийн эзэмшлийн компаниуд эзэлж байна.

**ЗУРАГ 2-1. СУДАЛГААНЫ ТҮҮВЭР, САЛБАР (ХУВИАР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачдын тооцоолол.


**ЗУРАГ 2-2. СУДАЛГААНЫ ТҮҮВЭР, ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР (ХУВИАР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачдын тооцоолол.


Борлуулалтын орлогоор нь аж ахуй нэгжийн хэмжээг тодорхойлсон бөгөөд үүнд 100 сая төгрөгөөс бага борлуулалттай бол бичил, 100-500 сая төгрөг бол жижиг, 500 саяас 3,2 тэрбум төгрөг бол дунд аж ахуйн нэгж гэж ангиллаа. (Зураг 2-4)

**ЗУРАГ 2-3. СУДАЛГААНЫ ТҮҮВЭР, БАЙГУУЛАГДСАН ОН (ХУВИАР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачдын тооцоолол.

**ЗУРАГ 2-4. СУДАЛГААНЫ ТҮҮВЭР, ХЭМЖЭЭ (ХУВИАР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачдын тооцоолол.

Судалгаанд оролцогсдын ихэнх нь 5-аас дээш жил үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 1-9 тооны ажилчидтай, 31,8 хувь нь жилийн 100 хүртэлх сая төгрөгийн борлуулалтын орлоготой, 40 хувь нь жижиг компаниуд хамрагдсан байна. (Зураг 2-3, Хүснэгт 2-1)

**ХҮСНЭГТ 2-1. ЖДҮ ЭРХЛЭГЧДИЙН АЖИЛЧДЫН ТОО**

Ажилчдын тооны бүлэг	Хувь
1-9	51,9
10-19	22,7
20-49	18,2
50+	7,2

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачдын тооцоолол.

### 3. ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

#### 3.1. Албан ёсны бүртгэлтэй холбоотой хэлцлийн зардал

ААН-ийг улсын бүртгэлд албан ёсоор бүртгүүлэх нь байгууллагадаа болон бизнесийн эзэд, ажилчдад аль алинд нь олон давуу тал авчирдаг. Бизнесийг үүсгэн байгуулсан хувь нийлүүлэгчид нөөцөө нэгтгэж хууль ёсны аж ахуйн нэгж байгуулснаар төрийн байгууллага, банк санхүүгийн үйлчилгээ авах, шинэ зах зээлд нэвтрэх боломжтой болно. Ажилчид нь мөн хуулийн хамгаалалтад ордог. Ялангуяа хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулснаар компанийн эзийн санхүүгийн хариуцлага хувь нийлүүлсэн хөрөнгөөр нь л хязгаарлагдах бөгөөд эзийн хувийн өмч эрсдэлд орохгүй юм. ААН-ийн бүртгэл энгийн хялбар байвал аж ахуйн нэгжүүд албан секторт үйл ажиллагаагаа эхлүүлж, илүү сайн ажлын байр бий болгож, өөрсөддөө болон төрд илүү их орлого бүрдүүлдэг. Энэ хэсэгт ЖДҮ-ийн салбарын бизнес эрхлэгчид бизнесээ эхлүүлэхэд хэр их зардал гаргаж байгааг нарийвчлан судлах юм.

Дэлхийн Банкны жил тутам гүйцэтгэдэг “Бизнес эрхлэхүй” судалгаанд тухайн улсад аж ахуйн нэгж байгуулахтай холбоотой зардал чирэгдэл хэр байгааг нарийвчлан хэмжиж, бусад улс оронтой харьцуулдаг. Уг судалгаанд 10-50 ажилтантай, Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулдаг, 100 хувь дотоодын хөрөнгө оруулалттай, үл хөдлөх хөрөнгө эзэмшдэггүй, жилийн борлуулалтын орлого нь нэг хүнд ноогдох жилийн ДНБ-ээс дор хаяж 100 дахин их ХХК-г хамруулснаараа түүвэрлэлтийн хувьд бидний судалгаанаас ялгаатай болдог. Гол хэмжэдэг үзүүлэлтүүд нь хууль ёсоор бизнес эхлүүлэхэд шаардлагатай алхмын тоо (нэр авах, нотариатаар батлуулах, татвар ба нийгмийн даатгалд бүртгүүлэх, байгууллагын тамга авах гэх мэт), алхам бүрийг гүйцэтгэхэд шаардагдах хоног (зөвлөгөө мэдээлэлд зарцуулах хугацааг оруулаагүй, онлайнаар гүйцэтгэж болох алхмыг хагас өдөр зарцуулна гэж тооцдог), алхам бүрд шаардагдах албан ёсны төлбөр, хураамжийн зардал, бүртгүүлэхээс өмнө банкинд байршуулах хөрөнгө зэрэг юм.

**ХҮСНЭГТ 3-1. МОНГОЛД БИЗНЕС ЭХЛҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ  
АЛХАМ, ХУГАЦАА, ЗАРДАЛ**

№	Алхам	Шаардах хугацаа	Төлбөр хураамж
1	Татварын ерөнхий газрын Улсын бүртгэлийн хэлтэс дээр нэр шүүх	1 өдөр	500 төгрөг
2	Арилжааны банкинд бүртгэлийн хураамж төлөх	1 өдөр	шимтгэлгүй
3	ООУБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн хэлтэст бүртгүүлэх	7 өдөр	22'500 төгрөг
4	Харьяа дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст бүртгүүлэх	1 өдөр	хураамжгүй
5	ААН-ийн тамга хийлгэх	1 өдөр	46'000 төгрөг

Эх сурвалж: (World Bank, 2014).

“Бизнес эрхлэхүй 2015” (World Bank, 2014) судалгаагаар бизнес эхлүүлэхэд албан ёсоор дараах 5 алхам хэрэгжүүлж, үүнд 11 өдөр, 79'000 төгрөг зарцуулж байжээ. Энэ нь судалгаанд хамрагдсан 189 орноос 42-т орох сайн үзүүлэлт юм. (Хүснэгт 3-1)

Харин бид судалгаандаа аж ахуйн нэгжүүд бизнесээ эхлүүлэхэд шаардлагатай бусад зардал буюу уг ажлыг хариуцсан хүмүүсийн алдсан цаг хугацааны өртөг, мэдээлэл зөвлөгөө хайх зардал, төрийн байгууллагын шийдвэр хоцорсноос үүсэх алдагдал, албан бус төлбөр (авилга) гэх мэт “зах зээлийн бус хэлцлийн зардлыг” голлон авч үзэв. Үүнээс гадна байгууллагын бүртгэлтэй холбоотой асуудлаар ямар эх сурвалжаас мэдээлэл зөвлөгөө авсан, бүртгэлийн ажлыг тухайн аж ахуйн нэгжээс хэн голлон хариуцсан, ижил төстэй байгууллагатай харьцуулахад тухайн байгууллагын албан ёсны бүртгэлийн үйл ажиллагаа

хэр хэцүү байсан, Улсын бүртгэлийн газрын ЖДУ-ийн бүртгэлд бүртгүүлсэн эсэх, бүртгүүлээгүй бол үүний шалтгаан, хэрвээ хэн нэгэнд компанийн бүртгэлийг хийж өгөхөөр бол хэдэн төгрөгөөр уг ажлыг хөөцөлдөж өгөх, бүртгэл хариуцсан төрийн байгууллагын үйл ажиллагаа хэр хөнгөн шуурхай байсан, албан ёсоор бизнес эрхлэхийн хүндрэлтэй талууд юу болох, бизнесээ албан ёсоор хаах (дампуурах) хэр төвөгтэй гэх мэт асуултаар нэмэлт мэдээлэл цуглууллаа.

Судалгаанд хамрагдсан 954 аж ахуйн нэгж бүртгэлийн үйл ажиллагаанд ямар нэг “зах зээлийн бус” хэлцлийн зардал гаргасан бөгөөд уг зардал дунджаар 822 мянган төгрөг байжээ. Энэ нь дунджаар борлуулалтын орлогынх нь 0,4 хувь байгаа юм.

#### **ХҮСНЭГТ 3-2. БҮРТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ХЭЛЦЛИЙН ЗАРДАЛ**

<b>Зардал</b>	<b>Зардал гаргасан байгууллагын тоо</b>	<b>Дундаж зардал, мянган төгрөгөөр</b>	<b>Борлуулалтын орлогод эзлэх хувь</b>
Бүртгэлийн мэдээлэл олж авах, зөвлөгөө авахад гарсан зардал	432	311	0,25
Бүртгүүлэх, бүртгэл шинэчлэх, төрийн байгууллагаас бүртгэл удаасантай холбоотой алдагдсан боломжийн өртөг	913	700	0,31
Бүртгэлийн үеэр төлсөн албан бус төлбөр	36	289	0,28
Бүртгэлтэй холбоотой нийт хэлцлийн зардал	954	822	0,42

*Эх сурвалж:* Түүвэр судалгааны үр дүн, судлаачдын тооцоолол.


Бүртгэлтэй холбоотой хэлцлийн зардлын дийлэнх нь уг ажлыг компанийн зүгээс хариуцсан ажилтнуудын зарцуулсан, хүлээсэн цаг хугацааны зардал байна. Бүртгэлийн ажлыг 1 хүн хариуцаж ажилласан тохиолдол 67 хувь, 2 хүн хариуцсан тохиолдол 24 хувь байна. Энэ зардал 912 байгууллагад дунджаар 664 мянган төгрөг байжээ. Мөн хэлцлийн зардалд төрийн байгууллагын хариуцлагагүй байдлаас болж учирсан зардлуудыг оруулав. Тухайлбал, судалгаанд оролцогчдын 2,7 хувь нь бүртгүүлэх үед төрийн байгууллагын буруугаас ямар нэг бичиг баримт нь алга болж, үрэгдэж байжээ. Мөн бүртгэл хариуцсан төрийн байгууллага нь ЖДУ-ийн 7,9 хувьд шийдвэрээ журамд зааснаас хоцроож гаргасан бөгөөд энэ чирэгдлийг ЖДУ-үүд дунджаар 25 хоног буюу 437 мянган төгрөг гэж үнэлжээ. Эдгээр алдагдсан боломжийн өртөг байгууллагын борлуулалтын орлогын 0,3 хувьтай тэнцэж байгаа юм.

ЖДУ-ийн 28 хувь нь авилга, бэлэг сэлт зэрэг албан бус төлбөр төлбөл бүртгэлийн ажил хурдасна гэж итгэдэг бөгөөд 3,9 хувь нь бүртгэлтэй холбоотой ажил гүйцэтгэхдээ төрийн албан хаагчдад дунджаар 289 мянган төгрөгийн албан бус төлбөр төлжээ. (Хүснэгт 3-2)

Аж ахуйн нэгжүүдийн хэлцлийн зардлын дунг ангилж харвал дийлэнх нь 500 мянга хүртэлх төгрөг зарцуулсан бол 15 хувь нь 2,5 сая төгрөгөөс дээш зардал гаргажээ. Энэ зардлыг тухайн байгууллагын жилийн борлуулалтын орлогод нь харьцуулж харвал, аж ахуйн нэгжүүдийн тал илүү хувь нь жилийн борлуулалтын орлогынхоо 0,2 хувиас хэтрэхгүй бүртгэлийн хэлцлийн зардалтай тулгарчээ. Гэхдээ 10 хувь нь жилийн борлуулалтын орлогынхоо 1 хувиас давах хэлцлийн зардал гаргажээ. (Зураг 3-1)

Уг үр дүнг харьцуулах зорилгоор нэмэлт асуулт асуун (хэрвээ бусдад бүртгэлийн хариуцаж хийж өгвөл хэдэн төгрөгийн хөлс авах вэ?), хэлцлийн зардлыг ойролцоогоор үнэлүүлэхэд нийт судалгаанд оролцогчдын 533 нь хариулт өгчээ. Тэд аж ахуйн нэгжийн бүртгэлийг дунджаар 1,4 сая төгрөгөөр хийнэ гэж хариулжээ. Энэ нь тэдний бүртгэлд зарцуулсан дундаж хэлцлийн зардал (822 мянган төгрөг)-аас нэлээд өндөр байна.

**ЗУРАГ 3-1. БҮРТГЭЛИЙН ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГОД ЭЗЛЭХ ХУВИЙН ТАРХАЛТ**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.


Бүртгэлтэй холбоотой хэлцлийн зардлын ачаалал нь байгуулагдсан он, үйл ажиллагааны салбар, бизнесийн хэмжээ зөргээс хамаарч ЖДҮ-дэд ялгаатай байх нь ойлгомжтой. Тухайлбал, шинэ компаниудын борлуулалтын орлогод харьцуулсан хэлцлийн зардал бусдаас өндөр байгаа бөгөөд эдгээр аж ахуйн нэгжийн борлуулалт бага байдагтай холбоотой. Мөн удаан ажилласан байгууллагууд бүртгэлийн талаар туршлагажиж, дараагийн удаад бүртгэлээ шинэчлэхдээ харьцангуй бага зардал гаргадаг байж болох юм. (Зураг 3-2)

Харин үйл ажиллагааны салбараар авч үзвэл, хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчдэд шинээр бүртгүүлэх, бүртгэлээ шинэчлэхтэй холбоотой хэлцлийн зардал харьцангуй их ачаалал учруулж байна. Хэдийгээр тус салбарынхан илүү бага хэлцлийн зардалтай тулгардаг (ХАА 708 мянга, аж үйлдвэр 889 мянга, үйлчилгээ 790 мянган төгрөг) боловч тэдний борлуулалтын орлого бусад салбараас эрс бага байгаа нь уг ачааллыг нэмж байна.

Аж ахуйн нэгжийн хэмжээгээр хэлцлийн зардлын мөнгөн дүнг харьцуулбал дунд хэмжээний бизнес эрхлэгчид дунджаар 1,4 сая төгрөг, жижиг бизнес эрхлэгчид 0,7 сая, бичил бизнес эрхлэгчид 0,4 сая төгрөг байна. Мөн бизнесийн хэмжээ томрох тусам бүртгэл хариуцсан ажилтны зарцуулсан цагийн үнэлэмж мэдэгдэхүйц өндөр байна. Гэхдээ борлуулалтын орлогод ноогдох хэлцлийн зардлыг авч үзэхэд аж ахуйн нэгжийн хэмжээ багасах тусам зардлын ачаалал нэмэгдэж байгаа нь харагдаж байна. (Зураг 3-2)


Хэлцлийн зардлыг тухайн байгууллагад ажилчдын тоогоор илэрхийлбэл, дунджаар нэг ажилтанд ноогдох хэлцлийн зардал 111 мянган төгрөг бөгөөд аж ахуйн нэгжүүдийн дөрөвний нэг нь нэг ажилтанд ноогдох дунгээр 100 мянган төгрөгөөс их хэлцлийн зардал гаргажээ. (Зураг 3-3)

**ЗУРАГ 3-3. НЭГ АЖИЛТАНД НООГДОХ ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН ТАРХАЛТ (МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

**ЗУРАГ 3-2. БҮРТГЭЛИЙН ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН АЧААЛАЛ (ХУВИАР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

**ЗУРАГ 3-4. ЖДҮ-ИЙН АЛБАН ЁСНЫ БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭЭГҮЙ ШАЛТГААН (ХУВИАР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

2007 онд батлагдсан ЖДҮ-ийн тухай хуульд заахдаа, ЖДҮ-ийн тусгай бүртгэлд бүртгүүлсэн аж ахуйн нэгжийг ЖДҮ эрхлэгчид тооцож, холбогдох дэмжлэгт хамруулна гэсэн байдаг. Гэвч, Хөдөлмөрийн яамны ЖДҮ-ийн газрын мэдээлснээр, уг бүртгэлд маш цөөн (2500 орчим) аж ахуйн нэгж бүртгүүлжээ. Бид судалгааныхаа үеэр ЖДҮ эрхлэгчдээс уг бүртгэлд албан ёсоор бүртгүүлээгүй шалтгааныг асуухад, ерөнхийдөө уг бүртгэлийн ач холбогдлын талаар ойлголт, мэдээлэл муутай байгаа хариулт өгсөн юм. Гэхдээ уг бүртгэлтэй холбоотой зардал чирэгдлээс төвөгшөөсөн хувь ч чамгүй байжээ. (Зураг 3-4)

Бизнесээ хууль ёсоор эхлүүлэх үйл ажиллагааг хөнгөвчлөх олон сайн туршлагыг улс орнууд нэвтрүүлсэн байдаг. Тухайлбал, Дэлхийн банкны “Бизнес эрхлэхүй 2015” судалгаанд хамрагдсан 189 орны 97 нь онлайн бүртгэлийг нэвтрүүлсэн бол 100 нь бизнесийн бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлсэн байна. Харин манай улсын хувьд дээрх үйлчилгээнүүд хараахан нэвтрээгүй байсаар байна. Бизнес эхлүүлэхэд тодорхой хэмжээний хөрөнгийг банкинд байршуулахыг зарим улс орон шаарддаг. Судалгаанд хамрагдсан орнуудаас 104 нь энэ шаардлагыг тавихаа больсон бөгөөд тэдний тоонд манай улс орсон нь бүртгэлтэй холбоотой зардал чирэгдлийг бууруулах сайн жишээнд тооцогдож байна.


Түүвэр судалгаанаас үзэхэд, бизнес эрхлэгчид бүртгэлтэй холбоотой мэдээлэл хайх, зөвлөгөө авахдаа төрийн байгууллагад хандахаас илүү мэргэжлийн хүмүүст хувийн журмаар хандах нь их байна. (Зураг 3-5) Нөгөө талаас, ЖДҮ эрхлэгчид ерөнхийдөө бүртгэлийн байгууллагын үйлчилгээнд дунд зэргийн сэтгэл ханамжтай байна. (Зураг 3-6) Энэ нь бизнесийн бүртгэлийн талаарх мэдээллийн хүртээмжийг нэмэх, үйлчилгээг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

**ЗУРАГ 3-5. БҮРТГЭЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ (ХУВИАР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

**ЗУРАГ 3-6. БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР (ХУВИАР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

Энэ хэсгийг дүгнэхэд, хэдийгээр ЖДҮ-үүд бизнесийн бүртгэлийн үйлчилгээ авах шаардлага бага гардаг боловч, бүртгэлтэй холбоотой гарах зардал чирэгдэл багагүй байна.

### 3.2. Тусгай зөвшөөрөл ба мэргэжлийн хяналттай холбоотой хэлцлийн зардал

Бизнесийн үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, хяналт тавих нь төрийн зохицуулалтын түгээмэл хэлбэр юм. Аливаа орны төр ажилчдын болон хэрэглэгчдийн эрх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах, өрсөлдөөнийг шударга байлгах, онцгой нөөцийг хуваарилах гэх мэт зорилгоор бизнесийн үйл ажиллагааг зохицуулж, хязгаарлаж байдаг. Гэхдээ эдгээр зайлшигүй зохицуулалт үр ашигтай байж, бизнесийн үйл ажиллагаанд хэт их дарамт учруулахгүй байх шаардлагатай. Хэрвээ бизнесийн үйл ажиллагаанд зөвшөөрөл авах, хяналт шалгалтыг давахад их хэмжээний цаг хугацаа, мөнгө шаардагдаж байвал бизнесүүд уг зах зээлийг орхих, эсвэл авилга өгөх замаар зөвшөөрөл авч, хяналт шалгалтыг давах, эсвэл хууль бусаар үйл ажиллагаа явуулж олон нийтэд эрсдэл

учруулах зэргээр нийгэмд хохиролтой үр дүнд хүрнэ. Харин зөвшөөрөл авах, мэргэжлийн хяналтаар шалгуулах үйл ажиллагаа хялбар, энгийн, хямд байвал бүгд хожно.

Дэлхийн банкны “*Бизнес эрхлэхүй 2015*” (World Bank, 2014) судалгаанд барилгын салбарт бизнес эрхлэгч 200 мянган ам.доллароос дээш өртөгтэй, ерөнхий зориулалттай агуулахын барилгыг дэд бүтцийн хамт шинээр барих зөвшөөрөл авахад хэчинээн алхам, цаг хугацаа, зардал гаргаж байгааг судалжээ. Гол хэмждэг үзүүлэлтүүд нь хууль ёсоор агуулах барихад шаардлагатай алхмын тоо (холбогдох бүх баримт бичгийг бүрдүүлэх, тодорхойлолт, зөвшөөрөл авах, цахилгаан, цэвэр бохир усны системд холбуулах, агуулахыг бүртгүүлэх гэх мэт), алхам бүрийг гүйцэтгэхэд шаардагдах хоног (зөвлөгөө мэдээлэлд зарцуулах хугацааг оруулаагүй, онлайнаар гүйцэтгэж болох алхмыг хагас өдөр зарцуулна гэж тооцдог), зардал (зураг төсөл бэлтгэх, дэд бүтцэд холбогдох гэх мэт) зэрэг юм.

Тус судалгаагаар агуулахын барилга барих зөвшөөрөл авахад Монголд албан ёсоор 16 алхам, 137 өдөр шаардагдах бөгөөд агуулахын өртгийн 0,02 хувьтай тэнцэх зардал гардаг (288 сая орчим төгрөгийн агуулахын хувьд 70 мянган төгрөг) гэжээ. Энэ нь судалгаанд хамрагдсан 189 орноос 74-д орох үзүүлэлт бөгөөд Зүүн ази, Номхон далайн бүсийн дундажтай ойролцоо байна.

Харин бид тайлангийн энэ хэсэгт ЖДҮ эрхлэгчид бизнесийн үйл ажиллагаа явуулахдаа шаардлагатай зөвшөөрөл лиценз авах, мэргэжлийн хяналтын байгууллагатай харилцах явцад гаргаж буй “зах зээлийн бус хэлцлийн зардал” буюу уг ажлыг хариуцсан хүмүүсийн алдсан цаг хугацааны өртөг, мэдээлэл зөвлөгөө хайх зардал, төрийн байгууллагын шийдвэр хоцорсноос үүсэх алдагдал, албан бус элдэв төлбөр (авилга) гэх мэтийг авч үзлээ. Мөн эдгээр үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, зөвлөгөөг ямар эх сурвалжаас авдаг, тухайн үйл ажиллагааг байгууллагаас хэн голчлон хариуцдаг, ижил төстэй байгууллагатай харьцуулахад тухайн үйл ажиллагаа хэр төвөгтэй байсан, хэн нэгэнд бизнесийн тусгай зөвшөөрөл хөөцөлдөж өгөх бол хэдэн төгрөгөөр гүйцэтгэх, эдгээр үйл ажиллагааг эрхэлдэг төрийн байгууллагууд хэр хөнгөн шуурхай байсан гэх мэт асуултаар нэмэлт мэдээлэл цуглувлав.

### **3.2.1. Тусгай зөвшөөрөл авахтай холбоотой хэлцлийн зардал**

Судалгаанд оролцогчдын тал буюу 55 хувь нь үйл ажиллагаа эрхлэхдээ ямар нэг зөвшөөрөл лиценз төрийн байгууллагаас авсан бөгөөд түүн дотроос 62 хувь нь зөвшөөрлөө байнга шинэчлэх шаардлагатай байдаг ажээ. Бизнес эрхлэгчдийн 777 нь буюу 50,4 хувь нь тусгай зөвшөөрөл, лиценз авах үйл ажиллагаанд дунджаар 1,6 сая төгрөгийн хэлцлийн зардал гаргасан бөгөөд энэ нь дунджаар борлуулалтын орлогын 0,84 хувь юм.

Тусгай зөвшөөрөлтэй холбоотой хэлцлийн зардлын дийлэнх нь уг ажлыг компанийн зүгээс хариуцсан ажилтнуудын зарцуулсан, хүлээсэн цаг хугацааны зардал байна. Мөн тусгай зөвшөөрөл хариуцсан төрийн байгууллага нь аж ахуйн нэгжүүдийн 17,5 хувьд шийдвэрээ хоцроож гарган чирэгдэл учруулжээ. Энэ хоёр төрлийн зардал нь нийлээд 756 байгууллагад дунджаар 1,4 сая орчим төгрөг буюу борлуулалтын орлогын 0,67 хувьтай тэнцэх зардал учруулжээ.

### ХҮСНЭГТ 3-3. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ХОЛБООТОЙ ХЭЛЦЛИЙН ЗАРДАЛ


Хэлцлийн зардлын төрөл	Зардал гаргасан ЖДҮ-ийн тоо	Дундаж зардал, мянган төгрөг	Борлуулал- тын орлогод эзлэх хувь
Тусгай зөвшөөрлийн талаар зөвлөгөө, мэдээлэл авахад гарсан зардал	354	498	0,4
Тусгай зөвшөөрөл авах, төрийн байгууллагаас зөвшөөрлийг удаасантай холбоотой алдагдсан боломжийн өртөг	756	1364	0,7
Тусгай зөвшөөрөл авах үед төлсөн албан бус төлбөр	38	1117	0,6
Тусгай зөвшөөрөлтэй холбоотой нийт хэлцлийн зардал	777	1609	0,8

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачдын тооцоолол.

Зөвшөөрөл авах ажлыг тухайн байгууллагаас ихэвчлэн 1-2 хүн хариуцаж ажиллажээ. (1 хүн хариуцсан 56%, 2 хүн хариуцсан 32%) Энэ хэлцлийн зардалд төрийн байгууллагын хариуцлагагүй байдлаас болж учирсан зардлыг орууллаа. Тухайлбал, зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдийн 17,5 хувь нь зөвшөөрлөө журамд заасан хугацаанаас хоцроож авчээ. (13% нь 3 сараас дээш хугацаагаар хоцорсон байна.) Мөн ЖДҮ-ийн 4,5 хувь нь тусгай зөвшөөрөл авахдаа төрийн албан хаагчдад дунджаар 1,1 сая төгрөгийн ямар нэг албан бус төлбөр төлжээ. (Хүснэгт 3-3)


ЖДҮ-үүдэд тулгарсан хэлцлийн зардал ялгаатай бөгөөд тал хувь нь 500 мянга хүртэлх төгрөгийг энэ төрлийн хэлцлийн зардалд гаргасан бол 7 хувь нь 5 сая төгрөгөөс дээш зардал гаргажээ. Энэ зардлыг тухайн байгууллагын жилийн борлуулалтын орлогод нь харьцуулж харвал, аж ахуйн нэгжүүдийн тал хувь нь борлуулалтын орлогынхoo 0,2 хувиас хэтрэхгүй зөвшөөрлийн хэлцлийн зардалтай тулгарчээ. Харин 16 хувь нь борлуулалтын орлогынхoo 1 хувиас давах энэ төрлийн хэлцлийн зардал гаргажээ. (Зураг 3-7)

**ЗУРАГ 3-7. НИЙТ ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГОД ЭЗЛЭХ ХУВИЙН ТАРХАЛТ**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачдын тооцоолол.

**ЗУРАГ 3-8. ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ХОЛБООТОЙ ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН АЧААЛАЛ (ХУВИАР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачдын тооцоолол.


Уг үр дүнг харьцуулах зорилгоор нэмэлт асуулт асууж (хэрвээ бусдад тусгай зөвшөөрлийг нь хөөцөлдөж өгөх бол хэдэн төгрөгийн хөлс авах вэ?), хэлцлийн зардлыг ойролцоогоор үнэлүүлэхэд нийт судалгаанд оролцогчдын 421 нь тусгай зөвшөөрлийг дунджаар 1,6 сая төгрөгөөр авч өгнө гэж хариулжээ. Энэ нь тэдний тусгай зөвшөөрөл авахад зарцуулсан нийт хэлцлийн зардал (1,6 сая төгрөг)-тай адил байна.

Зөвшөөрөл авахтай холбоотой хэлцлийн зардлын ачааллыг тухайн аж ахуйн нэгжийн байгуулагдсан он, үйл ажиллагааны салбар, бизнесийн хэмжээ зэргээр ялгаж авч үзье. Ингэхэд, уг хэлцлийн зардлын борлуулалтын орлогод харьцуулсан харьцаа шинэ, хуучин компаниудын хооронд төдийлөн ялгаагүй байна. (Зураг 3-8) Харин үйл ажиллагааны

салбараар авч үзвэл, хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчид үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авахад харьцангуй их хэлцлийн зардалтай тулгарч байна. Хэдийгээр тус салбарынхан мөнгөн дүнгээрээ харьцангуй бага хэлцлийн зардалтай тулгардаг (ХАА-1,5 сая, аж үйлдвэр-2,3 сая, үйлчилгээ-1,2 сая төгрөг) боловч тэдний борлуулалтын орлого бусад салбараасаа эрс бага байгаа нь уг ачааллыг нэмж байна. Аж ахуйн нэгжийн хэмжээгээр тус хэлцлийн зардлын мөнгөн дүнг харьцуулбал дунд хэмжээний бизнес эрхлэгчид дунджаар 2,2 сая төгрөг, жижиг бизнес эрхлэгчид 1,5 сая, бичил бизнес эрхлэгчид 0,9 сая төгрөг байна. Мөн бизнесийн хэмжээ томрох тусам тусгай зөвшөөрөл хариуцсан ажилтны зарцуулсан цагийн үнэлэмж эрс өндөр байна. Гэхдээ борлуулалтын орлогод ноогдох хэлцлийн зардлыг авч үзэхэд аж ахуйн нэгжийн хэмжээ багасах тусам зардлын ачаалал нэмэгдэж байна.


Зөвшөөрөлтэй холбоотой хэлцлийн зардлыг тухайн байгууллагад ажилчдын тоотой харьцуулж харвал, аж ахуйн нэгжийн гуравны нэг нь нэг ажилтанд ноогдох дүнгээр 100 мянгаас дээш төгрөгийн хэлцлийн зардал гаргажээ. Дунджаар нэг ажилтанд ноогдох хэлцлийн зардал 217 мянган төгрөг байна. (Зураг 3-9)

**ЗУРАГ 3-9. ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ХОЛБООТОЙ, НЭГ АЖИЛТАНД НООГДОХ ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН ТАРХАЛТ (ХУВИАР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

**ЗУРАГ 3-10. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ (ХУВИАР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

Ерөнхийдөө бизнес эрхлэгчид тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл хайх, зөвлөгөө авахдаа төрийн албан эх сурвалжаас илүүтэй мэргэжлийн хүмүүст хандах нь их байна. (Зураг 3-10)


Гэхдээ ЖДҮ эрхлэгчид ерөнхийдөө тусгай зөвшөөрөл олгодог төрийн байгууллагын үйлчилгээнд сэтгэл ханамж харьцангуй сайн байна. (Зураг 3-11)

### 3.2.2. Мэргэжлийн хяналттай холбоотой хэлцлийн зардал

Судалгаанд оролцогчдын 27 хувьд нь өнгөрсөн жил мэргэжлийн хяналтын байгууллага ямар нэг асуудлаар ханджээ. Хандсан асуудлын дийлэнх нь эрүүл ахуй, ариун цэврийн стандарт байв. (Зураг 3-12) Нарийвчилж харвал, сүүлийн нэг жилд мэргэжлийн хяналтын

байгууллага бичил бизнес эрхлэгчдийн (80 хувь нь үйлчилгээ эрхэлдэг) 75 хувьд эрүүл ахуй, ариун цэврийн, 7 хувьд галын аюулгүй байдал, 6 хувьд хөдөлмөр хамгааллын шалгалт


**ЗУРАГ 3-11. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ (ХУВЬ)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.


хийжээ. Харин дунд хэмжээний ЖДҮ-ийн 46 хувьд нь эрүүл ахуй, ариун цэврийн, 26 хувьд хөдөлмөр хамгаалал, 11 хувьд барилга ашиглалтын асуудлаар ханджээ.

**ЗУРАГ 3-12. МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГААС ХАНДСАН АСУУДАЛ (ХУВИАР)**



*Эх сурвалж:* Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

**ЗУРАГ 3-13. МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАРТАЙ ХАРИЛЦАХ ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН АЧААЛЛЫН ТАРХАЛТ (ХУВИАР)**



*Эх сурвалж:* Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

Бизнес эрхлэгчид МХГ-ын тавьсан шаардлагыг биелүүлэхийн тулд дунджаар 1,3 сая төгрөгийн хэлцлийн зардал гаргасан бөгөөд энэ нь борлуулалтын орлогын 0,7 хувь юм. (Хүснэгт 3-4) МХГ-тай харилцаад гарсан хэлцлийн зардалд шууд зардал дийлэнх хувийг эзэлж байгаа бол уг ажлыг компанийн зүгээс хариуцсан ажилтнуудын зарцуулсан, хүлээсэн цаг хугацааны зардал харьцангуй бага хувийг эзэлж байгаа юм.

**ХҮСНЭГТ 3-4. МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ШААРДЛАГАТАЙ ХОЛБООТОЙ ХЭЛЦЛИЙН ЗАРДАЛ**

Зардал	Зардал гаргасан байгууллагын тоо	Дундаж зардал, мянган төгрөг	Борлуулалтын орлогод эзлэх хувь
МХГ-ын шаардлагыг биелүүлэхэд гарсан шууд зардал	324	1143	0,7
МХГ-тай харилцах асуудлыг хариуцсан хүмүүсийн цалин хөлс	385	342	0,2
МХГ-ын тавьсан асуудлыг шийдвэрлүүлэхийн тулд төлсөн албан бус төлбөр	29	239	0,2
МХГ-тай харилцаад гарсан нийт хэлцлийн зардал	406	1254	0,7

*Эх сурвалж:* Түүвэр судалгааны үр дүн, судлаачдын тооцоолол.


Энэхүү хэлцлийн зардлын дүнг ангилж харвал, ААН-ийн 49 хувь нь 500 мянга хүртэлх төгрөгийн хэлцлийн зардалтай тулгарсан бол 7 хувь нь 5 сая төгрөгөөс дээш зардал гаргажээ. Энэ зардлыг тухайн байгууллагын жилийн борлуулалтын орлогод нь харьцуулбал, ААН-ийн тал хувь нь борлуулалтын орлогынхoo 0,2 хувиас хэтрэхгүй, 17 хувь нь борлуулалтын орлогынхoo 1 хувиас давах хэлцлийн зардалтай тулгарчээ. (Зураг 3-13)

МХГ-тай харилцах хэлцлийн зардлын ачааллыг тухайн аж ахуйн нэгжийн байгууллагдсан он, үйл ажиллагааны салбар, бизнесийн хэмжээ зэргээр ялгаж авч үзье. Харьцуулж үзэхэд, уг хэлцлийн зардлын борлуулалтын орлогод харьцуулсан харьцаа шинэ компанийд харьцангуй өндөр байна. Энэ нь нэг талаас, шинэ байгууллагын борлуулалтын орлого бага тул хэлцлийн зардлын эзлэх хувь их байдагтай холбоотой боловч нөгөө талаас, үйл ажиллагаа нь жигдэрч амжаагүй шинэ байгууллагуудад янз бүрийн зөрчил гарч, МХГ-аас шаардлага тавих тохиолдол элбэг байдагтай холбоотой. (Зураг 3-14)

Үйл ажиллагааны салбараар авч үзэхэд энэ талын хэлцлийн зардлын ачаалал төдийлөн ялгаагүй байна. Харин бизнесийн хэмжээ жижиг байх тусам МХГ-тай харилцах зардлын ачаалал их байна.


МХГ-тай харилцах хэлцлийн зардлыг тухайн байгууллагад ажилчдын тоотой харьцуулж харвал, аж ахуйн нэгжийн 70 хувь нь нэг ажилтанд ноогдох дүнгээр 100 мянгаас доош, б хувь нь 500 мянгаас дээш төгрөгийн хэлцлийн зардал гаргажээ. Дунджаар нэг ажилтанд ноогдох хэлцлийн зардал 178 мянган төгрөг байна.

**ЗУРАГ 3-14. МХГ-ТАЙ ХАРИЛЦАХ ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН АЧААЛЛЫН ХАРЬЦУУЛАЛТ (ХУВИАР)**



*Эх сурвалж:* Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

**ЗУРАГ 3-15. МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ (ХУВИАР)**



*Эх сурвалж:* Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

Хэдийгээр бизнесийн үйл ажиллагаанд тодорхой зардал чирэгдэл учруулдаг боловч, тэдний эрсдэлийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг тул ЖДҮ эрхлэгчид ерөнхийдөө мэргэжлийн хяналтын байгууллагын үйлчилгээнд сэтгэл ханамж сайтай байна. (Зураг 3-15)


### 3.3. Гэрээний хэрэгжилттэй холбоотой хэлцлийн зардал

Бизнесийн хөгжилд нөлөөлөгч нэг гол хүчин зүйл нь бизнесийн түншүүдийн хоорондын гэрээнүүд хэлцлийн зардал багатай хэрэгжүүлэх явдал. Манай улсад бизнесийн харилцаанд тулгарч буй, гэрээний хэрэгжилтийг хангахтай холбоотой хэлцлийн зардлыг хэмжсэн судалгаа одоогоор хийгдээгүй байна. Бид энэ судалгаагаар уг зардлыг хэмжихийг оролдлоо. Ингэхдээ гэрээний хэрэгжилтийг хангах, маргаан шийдвэрлэх явцад гарах хэлцлийн зардлыг хэмжсэн ба эдгээр нь зах зээлийн бус хэлцлийн зардал юм. Харьцуулах үүднээс, бизнесийн түншүүдтэй гэрээ байгуулахад гарах зах зээлийн хэлцлийн зардлыг ч хэмжихийг зорилоо.

Бизнесийн үйл ажиллагаа амжилттай хэрэгжихийн тулд ажилтнуудтай, бэлтгэн нийлүү-лэгчидтэй, худалдан авагчидтай байгуулсан гэрээ зардал, чирэгдэл багатай, үр дүнтэй хэрэгждэг байх ёстой. Гэвч бизнесийн харилцааны явцад гэрээ зөрчигдөх, маргаан гарах, бизнес гэмт халдлагад өртөх тохиолдол гардаг. Энэ үед гэрээний хэрэгжилтийг хангах, маргааныг шийдвэрлэх, өмчлөх эрхийг хамгаалахын тулд төрийн байгууллагын оролцоо шаардагдана. Гол асуудал нь аливаа улс оронд гэрээний хэрэгжилтийг хангах төрийн оролцоо аль болох үр дүнтэй, үр ашигтай байх явдал юм.


Энэ судалгаанд тухайн аж ахуйн нэгж бизнесийн түншүүдтэйгээ сүүлийн гурван жилд гэрээний хэрэгжилтийн талаар маргаан үүсгэж байсан эсэхийг тодруулахад тэдний 8,1 хувь нь ийм маргаан үүсгэж байжээ. Харин маргаанаа гол төлөв хоорондоо гэрээг дахин хэлэлцэж шинэчлэх, эсвэл шүүхэд хандаж шийдүүлсэн байна.

**ЗУРАГ 3-16. МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ (ХУВИАР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

**ЗУРАГ 3-17. ГЭРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН ТАРХАЛТ**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

Гэрээний маргаан гарсан үед бизнес эрхлэгчид уг маргааныг жилд дунджаар 1,6 сая төгрөгийн шууд зардал (өмгөөлөгчийн хөлс, шүүхийн төлбөр, нотариатын төлбөр гэх мэт), 2,0 сая төгрөгийн шууд бус зардал (алдсан цаг хугацаа, мөнгөөр илэрхийлэгдэхгүй бусад зардал)-аар шийдвэрлэжээ. Мөн 10 бизнес эрхлэгч маргаанаа шийдүүлэхийн тулд дунджаар 718 мянган төгрөгийн албан бус төлбөр төлжээ.

Гэрээний маргаан үүсгэсэн бизнес эрхлэгчдийн 92 хувь нь уг маргаан шийдвэрлэх үйл ажиллагаанд дунджаар 2,9 сая төгрөгийн хэлцлийн зардал гаргасан бөгөөд энэ нь дунджаар тэдний борлуулалтын орлогын 1,7 хувь болж байна. (Хүснэгт 3-5)

**ХҮСНЭГТ 3-5. ГЭРЭЭНИЙ МАРГААН ШИЙДВЭРЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ХЭЛЦЛИЙН ЗАРДАЛ**

Зардал	Зардал гаргасан байгууллагын тоо	Дундаж зардал, мянган төгрөгөөр	Борлуулалтын орлогод эзлэх хувь
Гэрээний маргааныг шийдвэрлэхэд гарсан шууд зардал	108	1558	1,0
Гэрээний маргааныг шийдвэрлэхэд гарсан шууд бус зардал	77	2048	1,1
Гэрээний маргааныг шийдүүлэхээр төлсөн албан бус төлбөр	10	718	0,6
Гэрээний маргааныг шийдвэрлэхэд гарсан нийт зах зээлийн бус хэлцлийн зардал	115	2897	1,7
Гэрээ байгуулахтай холбоотой гарах зах зээлийн хэлцлийн зардал	1121	1234	0,6

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачдын тооцоолол.


Хэдийгээр гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан харьцангуй бага гардаг боловч ийм маргаан шийдвэрлэх нь гэрээг байгуулахтай холбоотой гарах зах зээлийн хэлцлийн зардлаас өндөр зардал учруулдаг болохыг дээрх хүснэгт харуулж байна. Энд гэрээ байгуулахтай холбоотой зах зээлийн хэлцлийн зардлыг хэмжихдээ тухайн аж ахуйн нэгж бэлтгэн нийлүүлэгч олж авах ба гэрээ байгуулах, худалдан авагч олж авах ба гэрээ байгуулахад гарах мөнгөөр илэрхийлэгдэх шууд зардал, мөнгөөр илэрхийлэгдэхгүй шууд бус зардлыг (зарцуулсан цаг гэх мэт) нийтэд нь авч үзэв.

Харин гэрээний маргаан шийдвэрлэхэд гарах хэлцлийн зардал аж ахуйн нэгжүүдэд хэр дарамт учруулдгийг тодруулж харвал, маргаан үүсгэсэн байгууллагуудын 14 хувь нь борлуулалтын орлогынхоо 2,5 хувиас их хэлцлийн зардлыг жилд гаргажээ. (Зураг 3-17)

Дээрх хэлцлийн зардлын дарамтыг тухайн бизнесийн байгуулагдсан он, салбар, хэмжээ зэргээр ангилж авч үзье. Доорх зургаас харахад байгуулагдаад олон жил болсон аж ахуйн


нэгжүүдэд уг зардлын дарамт маш бага байна. Энэ нь нэг талаас, олон жил ажиллаж байгаа аж ахуйн нэгжийн борлуулалтын орлого их байх хандлагатай тул хэлцлийн зардлын эзлэх хувь бага байгаатай холбоотой боловч, нөгөө талаас, тэд олон жилийн туршлагадаа тулгуурлан гэрээнд гарсан маргааныг зардал багатай шийддэг давуу талтай холбоотой. (Зураг 3-18)

**ЗУРАГ 3-18. ГЭРЭЭНИЙ МАРГААН ШИЙД-ВЭРЛЭХ ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН АЧААЛЛЫН ХАРЬЦУУЛАЛТ (ХУВИАР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

**ЗУРАГ 3-19. НЭГ АЖИЛТАНД НООГДОХ, ГЭРЭЭНИЙ МАРГААНТАЙ ХОЛБООТОЙ ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН ТАРХАЛТ (МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

Уг хэлцлийн зардлын дарамт нь ХАА-н бизнес эрхлэгчдэд маш бага дарамт учруулж байгаа нь энэ салбарын аж ахуйн нэгжүүд маргаан бараг үүсгээгүй, борлуулалтын орлого ихтэй, гарсан маргааныг харьцангуй зардал багатай шийдвэрлэдэгтэй холбоотой. Энэ дарамтыг бизнесийн хэмжээгээр харвал бичил бизнес эрхлэгчдэд учрах дарамт харьцангуй их байна. Хэлцлийн зардлыг тухайн байгууллагад ажилчдын тоотой харьцуулбал, аж ахуйн нэгжийн 49 хувь нь нэг ажилтандаа ноогдох дунгээр 100 мянгаас доош, 9 хувь нь 1 саяас дээш төгрөгийн хэлцлийн зардал гаргажээ. Дунджаар нэг ажилтандаа ноогдох хэлцлийн зардал 287 мянган төгрөг байна. (Зураг 3-19)

Энэхүү түүвэр судалгаанд гэрээний хэрэгжилтээс гадна байгууллагын өмчлөх эрхийг хангах асуудлыг авч үзлээ. Гэхдээ зөвхөн тухайн байгууллага гэмт халдлагад өртсөн тохиолдлыг асууж, оруулав. Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 9,9 хувь нь суулийн гурван жилд ямар нэг гэмт халдлагад өртөж, 8,6 хувь нь ямар нэг материаллаг хохирол амсжээ. Уг хохирлын дундаж хэмжээ 2,5 сая төгрөг байжээ. Тэдний 78 хувь нь халдлагад өртсөнийхөө дараа ямар нэг арга хэмжээ авсан бөгөөд дийлэнх нь эрх бүхий төрийн байгууллагад хандсан (58 хувь)-аас гадна цөөнгүй тохиолдолд халдлага хийсэн этгээдэд төлбөр төлөх (9 хувь), гуравдагч бүлэглэл, хувь хүнд хандах (6 хувь) зэрэг арга хэмжээ авчээ. Гэмт халдлагад өртсөн бизнес эрхлэгчдийн 58 хувь нь цаашид дахин халдлагад өртөхгүйн тулд жилд дунджаар 740 мянган төгрөгийн нэмэлт зардал гаргажээ.


### 3.4. Төрийн байгууллагатай харилцахтай холбоотой хэлцлийн зардал

Хөгжиж буй орнуудын хувьд бичил, жижиг, дунд үйлдвэрийн хөгжилд төрөөс баримтлах бодлого нэн чухал байдаг. Ялангуяа, тухайн улсад бизнес шинээр эрхлэх, эсвэл бизнесээ өргөжүүлж, хөгжүүлэхэд орчин хэр таатай байдаг талаар олон улсын байгууллагууд нэлээд судалсан байдаг. Бизнес эрхлэх орчин таатай байгаа бол төрийн институц сайн ажиллаж, аливаа бизнесийн үйл ажиллагаанд төрийн бодлого дэмжлэг үзүүлж байна гэсэн үг.

Энэ хэсэгт бид төрөөс бизнесийн орчны талаар явуулж буй бодлого, төрийн бараа, үйлчилгээний худалдан авалттай холбоотойгоор ЖДҮ эрхлэгчдэд учирч буй хэлцлийн зардлын эх сурвалжийг тодорхойлж, түүнийг ойролцоогоор хэмжсэн үр дүнг авч үзнэ. Түүвэр судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн 43,7 хувь нь ЖДҮ-ийн талаарх төрийн


бодлоготой холбоотой мэдээлэл муу, мэдээлэлгүй гэж хариулсан (Зураг 3-20) бол төрийн бодлогын хэрэгжилтийг талаас илүү хувь нь бүх шатанд сул гэж үнэлжээ. (Зураг 3-21) Тэгэхээр цаашид ЖДҮ-ийн талаар явуулж буй бодлогын талаарх мэдээллийн хүртээмжийг сайжруулах, бүх шатандаа хэрэгжилтийг хянаж, үнэлэх механизмыг бий болгох асуудалд анхаарах шаардлагатай.

**ЗУРАГ 3-20. ТӨРИЙН БОДЛОГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ (ХУВИАР)**



*Эх сурвалж:* Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

**ЗУРАГ 3-21. ТӨРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ (ХУВИАР)**




*Эх сурвалж:* Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

ЖДҮ-ийн талаарх төрийн бодлогын агуулгыг судалгаанд оролцогчдын 40 хувь нь муу, 49 хувь нь дундаж гэж үнэлсэн байна. Бизнес шинээр эхлүүлэх, эсвэл өргөжүүлэх, хөгжүүлэх зорилгоор төрөөс хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт хамрагдах хүсэлтээ ЖДҮ эрхлэгчдийн 24,6 хувь нь гаргасан бөгөөд хандсан хүсэлтийн 44,5 хувь нь үр дунд хүрээгүй ажээ. Эндээс дүгнэхэд ЖДҮ-ийн талаар хэрэгжүүлж буй бодлогыг хэрхэн томьёолж, хэрэгжүүлж байгаа нь тун бүрхэг байна. Судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн 21 хувь нь төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагад бараа, үлчилгээ нийлүүлсэн бөгөөд энэхүү үйл ажиллагаа нь хувийн сектортой харьцуулахад илүү зардалтай байсан гэж 25,2 хувь нь хариулжээ.

Төрийн байгууллага, орон нутгийн засаг захиргаатай харилцах болон төрийн байгууллагын худалдан авалттай холбоотой хэлцлийн зардлыг хэд хэдэн төрлөөр нарийвчлан хэмжлээ. Үүнд мэдээлэл хайх, олж авах, компанийн тухай шаардлагатай материал бэлтгэх, олшруулах, санхүүгийн шаардлагыг биелүүлэх, гуравдагч этгээдээс лавлагаа авах, баталгаа гаргуулах зэрэгт зарцуулсан зардал гэх мэт шууд зардал; төрийн байгууллагын эсрэг гомдол гаргах зэрэгтэй холбоотой шууд бус зардал; лавлагаа гаргуулах, баталгаа гаргах, худалдан авалтын талаар шийдвэр гаргах хүмүүст хариу барих, бэлэг сэлт, зоог, мөнгө өгөх зэрэг албан бус төлбөрийг багтаан орууллаа.


Энд 138 ЖДҮ эрхлэгч төрийн байгууллага, орон нутгийн засаг захиргаатай харилцах, төрийн байгууллагын худалдан авалттай холбоотой ямар нэг хэлцлийн зардал гаргасан бөгөөд тэдний гаргаж буй нийт хэлцлийн зардал дунджаар 3 сая төгрөг болжээ. Эдгээр аж ахуйн нэгжийн 71 хувь нь жилд дунджаар борлуулалтын орлогынхoo 1 хүртэл хувьтай тэнцэх хэлцлийн зардал гаргасан бол 9,4 хувь нь 1-2 хувьтай тэнцэх хэлцлийн зардал, 19,6 хувь нь 3-аас дээш хувьтай тэнцэх хэлцлийн зардлыг тус тус гаргажээ. Үүнийг нийт дүнгээр нь авч үзвэл төрийн байгууллага, орон нутгийн засаг захиргаатай харилцах, төрийн байгууллагын худалдан авалттай холбоотой нийт хэлцлийн зардал борлуулалтын орлогод 1,9 хувийг эзэлж байгаа бол үүнээс шууд зардал нь 1,5%, шууд бус зардал 1,4%, албан бус төлбөр 0,4 хувийг тус тус эзэлж байна.

**ЗУРАГ 3-22. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАРИЛЦАХ ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН АЧААЛЛЫН ТАРХАЛТ**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

**ЗУРАГ 3-23. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАРИЛЦАХ НЭГ АЖИЛТАНД НООГДОХ ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН ТАРХАЛТ**




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

Нэг ажилтандаа ноогдох хэлцлийн зардал бичил, жижиг үйлдвэрүүдэд харгалзан 454 ба 476,5 мянган төгрөг байгаа бол дунд хэмжээтэй үйлдвэрүүдэд 160,5 мянган төгрөг байна. ЖДҮ-ийн 44,2 хувийн нэг ажилтандаа ноогдох хэлцлийн зардал 50 мянган төгрөгөөс бага байна.

Энэ үйл ажиллагааны нийт хэлцлийн дундаж зардал 3,1 сая төгрөг байгаа бол шууд зардал 2,4 сая, шууд бус зардал 2,3 сая төгрөг, албан бус зардал 1,1 сая төгрөг байна. Нийт хэлцлийн зардлын борлуулалтын орлогод эзлэх хувийг эдийн засгийн салбарын ангиллаар харвал, бичил бизнес эрхлэгчид тулгарах дундаж зардал борлуулалтын орлогынх нь 3,6 хувьтай тэнцүү байгаа бол жижиг үйлдвэр эрхлэгчийнх үүнээс хоёр дахин бага байна. (Зураг 3-24)

Төрийн байгууллага, орон нутгийн засаг захиргаатай харилцах болон төрийн байгууллагын худалдан авалттай холбоотойгоор судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчийн 4 хувь нь төрийн байгууллагын эсрэг гомдол гаргасан бөгөөд гомдолоо шийдвэрлүүлэхийн тулд дунджаар 90 хоног хүлээсэн байна. Мөн салбар, мэргэжлийн холбоо, MYXAYT зэрэг төрийн бус байгууллагад өөрийн бизнестэй холбоотой асуудлаар хандсан ЖДҮ эрхлэгч 218 байгаагаас тэднийг дэмжих үйл ажиллагаанд зөвхөн 24 хувь нь үр дүнтэй, сайн дэмжлэг үзүүлдэг гэж хариулсан байна. Эдгээр байгууллагаас MYXAYT-ыг илүү сайн ажилладаг гэж үнэлжээ.

**ЗУРАГ 3-24. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАРИЛЦАХ ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН АЧААЛАЛ (ХЭМЖЭЭГЭЭР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

## 4. ТАТВАР БА ГААЛЬТАЙ ХОЛБООТОЙ ХЭЛЦЛИЙН ЗАРДАЛ


### 4.1. Татвартай холбоотой хэлцлийн зардал

Жижиг, дунд бизнесүүд том аж ахуйн нэгжүүдийг бодвол ихэвчлэн ашиг, орлого багатай, албан бус салбарт үйл ажиллагаа явуулах хандлагатай байдаг учраас улсын татварын орлогод төдийлөн том хувь нэмэр оруулдаггүй. Тэдний хувьд татварын түвшин өндөр, татварын хуулийн талаарх мэдлэг хомс байдаг нь татвар бага төлөхөд нөлөөлөхөөс гадна татварын албандаа тайлагнах, татвар төлөхтэй холбоотой зардал чирэгдэл нэмэлт хүндрэл учруулдаг. Татварын ачаалал их байх нь зөвхөн татвар өндөр буйн үр дүн биш, татвар төлөх үйл ажиллагааны зардалтай ч холбоотой.

Өндөр хөгжилтэй орнууд түүвэр судалгаагаар татвар төлөх хэлцлийн зардлыг тогтмол хэмжиж байдаг. Манай улсын хувьд Дэлхийн банкны “Business Environment Report 2015” (World Bank, 2014) судалгаанд дундаж хэмжээтэй, 2012 онд байгуулагдсан, хоёр дахь жилээс татвар төлж эхлэх аж ахуйн нэгжийг жишиг болгон авч, татвар төлөлттэй холбоотой үйл ажиллагааг судалсан байна. Ингэхдээ нийт хэдэн төрлийн татвар хураамжийг ямар хэлбэрээр, хэдэн удаа тайлagnаж төлсөн, татвар төлөхөд зарцуулах цаг, нийт татварын ачаалал зэрэг үзүүлэлтийг хэмждэг. Тус судалгааны үр дүнгээс харвал, дунджаар компаниуд жилд 41 удаа татвар төлөлт хийдэг бөгөөд татварын материал бүрдүүлэх, тайлagnах, татвар төлөхөд 148 цаг зарцуулж, борлуулалтын орлогынхоо 24 хувийг татварт төлдөг ажээ. Энэ нь судалгаанд хамрагдсан 189 орноос 84-т орох үзүүлэлт бөгөөд Зүүн ази, Номхон далайн бүсийн дундажтай ойролцоо байна.


Бид тайлангийн энэ хэсэгт ЖДУ эрхлэгчид татвар төлөхтэй холбоотой үйл ажиллагаанд гаргаж буй “зах зээлийн бус хэлцлийн зардал” буюу уг ажлыг хариуцсан хүмүүсийн зарцуулсан цаг хугацааны өртөг, мэдээлэл зөвлөгөө хайх зардал, татварын ба нийгмийн даатгалын байгууллагаас хийсэн шалгалттай холбоотой зардал, торгууль, албан бус төлбөрийг нарийвчлан авч үзсэн болно. Үүнээс гадна аж ахуйн нэгжүүд ямар төрлийн татвар төлдөг, татварын тайлан тушаалтад интернет ашигладаг эсэх, санхүүгийн бүртгэл тооцоог ямар хэлбэрээр гүйцэтгэдэг, бүртгэл тооцооны ажлыг хэн хариуцдаг, татварын талаар мэдээлэл зөвлөгөөг ямар эх сурвалжаас авсан, татварын албаны үйл ажиллагаа хэр хөнгөн шуурхай байсан, аж ахуйн нэгжүүд татварын хуулийг хэр сайн дагаж мөрддөг, татварын өнөөгийн тогтолцоо хэр шударга санагддаг гэх мэт асуултаар зарим нэмэлт мэдээлэл цуглууллаа.

ЗУРАГ 4-1. ЖДУ-ИЙН ТАТВАР ТӨЛӨЛТ  
(ХУВИАР)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

ЗУРАГ 4-2. ТАТВАРТАЙ ХОЛБООТОЙ  
ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН ТАРХАЛТ



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

Судалгаанд оролцогчид бараг бүгд нэмэгдсэн өргтийн албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлдөг бөгөөд бусад төрлийн татварыг ч нэлээд нь төлж байна. (Зураг 4-1)

Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн 98 хувь нь татвар төлөх асуудлаар ямар нэг хэлцлийн зардал гаргажээ Энэ нь дунджаар 3,4 сая төгрөг бөгөөд тэдний борлуулалтын орлогын 2 хувь болж байна. (Хүснэгт 4-1)

#### ХҮСНЭГТ 4-1. ТАТВАР ТӨЛӨХТЭЙ ХОЛБООТОЙ ХЭЛЦЛИЙН ЗАРДАЛ

Зардал	Зардал гаргасан байгууллагын тоо	Дундаж зардал, мянган төгрөгөөр	Борлуулалтын орлогод эзлэх хувь
Татварын талаар зөвлөгөө, мэдээлэл авахад гарсан зардал	649	305	0,2
Татвар төлөхтэй холбоотой гаргасан шууд бус хэлцлийн зардал	1493	2774	1,7
Татварын торгуультой холбоотойгоор байцаагчид төлсөн албан бус төлбөр	29	2174	1,3
Татвар төлөхтэй холбоотой нийт хэлцлийн зардал	1508	3433	2,0

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачдын тооцоолол.

Татвартай холбоотой гарах хэлцлийн зардал аж ахуйн нэгжүүдэд хэр дарамт учруулдгийг тодруулж харвал, байгууллагуудын 21 хувь нь борлуулалтын орлогынхоо 2,5 хувиас их хэлцлийн зардлыг жилд гаргажээ. Уг зардлын дийлэнх нь татвартай холбоотой санхүүгийн ажлыг хариуцсан хүний цалин хөлс, татвар нийгмийн даатгалын газраас сүүлийн жилүүдэд хийсэн шалгалттай холбоотой нэмж гарсан зардал байна. (Зураг 4-2)


Дээрх хэлцлийн зардлын дарамтыг тухайн бизнесийн байгуулагдсан он, салбар, хэмжээ зэргээр ангилж авч үзье. Доорх зургаас хараад байгуулагдсан он хэлцлийн зардлын ачаалалд төдийлөн нөлөөгүй байна. Харин уг үзүүлэлт салбараас болон хэмжээнээс нэлээд хамааралтай байна. Тухайлбал, ХАА-н бизнес эрхлэгчдийн болон дунд хэмжээний бизнес эрхлэгчдийн хэлцлийн зардлын ачаалал маш бага байна. Энэ нь эдгээр аж ахуйн нэгжийн борлуулалтын орлого харьцангуй их байдагтай голчлон холбоотой юм.

#### ЗУРАГ 4-3. ТАТВАРТАЙ ХОЛБООТОЙ ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН АЧААЛЛЫН ХАРЬЦУУЛАЛТ (ХУВИАР)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

#### ЗУРАГ 4-4. ТАТВАРТАЙ ХОЛБООТОЙ ХЭЛЦЛИЙН НЭГ АЖИЛТАНД НООГДОХ ЗАРДЛЫН ТАРХАЛТ (ХУВИАР)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

Татвар тайлагнах үйл ажиллагаа бизнесийн салбар, хэмжээнээс бараг хамаarahгүй ижил байдаг учраас үүнтэй холбоотой зардал нь орлого багатай, хүн цөөтэй аж ахуйн нэгжүүдэд харьцангуй илүү ачаалал учруулдаг байж болох юм. Дээрх хэлцлийн зардлыг нэг ажилтандаа ноогдох хэмжээгээр авч үзвэл дараах дүр зураг харагдаж байна. Тухайлбал, аж ахуйн нэгжүүдийн 38 хувь нь нэг ажилчинд ноогдох 100 мянган төгрөг хүргэлх татварын хэлцлийн зардалтай тулгарч байхад 11 хувь нь 1 ажилтандаа ноогдох дүнгээр 1 сая төгрөгөөс дээш зардалтай тулгарч байна. (Зураг 4-4)


Бидний хийсэн түүвэр судалгаанаас үзэхэд дийлэнх бизнес эрхлэгч татвартай холбоотой зөвлөгөө мэдээллийг цахим хуудас, төрийн байгууллагад хандаж авч байгаа нь харьцангуй эерэг хандлага юм. (Зураг 4-5)

**ЗУРАГ 4-5. ТАТВАРЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ (ХУВИАР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

**ЗУРАГ 4-6. ТАТВАРЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШУУРХАЙ БАЙДАЛ**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

ЖДҮ эрхлэгчид ерөнхийдөө татварын байгууллагын үйлчилгээнд дунд, дундаас дээгүүр сэтгэл ханамжтай байна. (Зураг 4-6)

#### **4.2. Гааль, гадаад худалдааны үйл ажиллагаатай холбоотой хэлцлийн зардал**


Даяаршлын нөлөөгөөр дэлхийн улс орнууд хоорондоо улам бүр хамааралтай болсоор байна. Тэд түүхий эд, аж үйлдвэрийн бараа, үйлчилгээний гадаад худалдааг нэмэгдүүлэх, үндэстэн дамнасан том компаниудаар дамжуулан гадаадын шууд хөрөнгө оруулалт хийх, олон улсын зээл, хувьцаа худалдан авах замаар багцын хөрөнгө оруулалт хийх зэргээр олон улсын зах зээлд идэвхтэй оролцох болжээ. ЖДҮ эрхлэгчдийн хувьд зөвхөн дотоодын зах зээл дээр бараа, үйлчилгээгээ борлуулахаас гадна гадаад зах зээл дээр өрсөлдөх нь чухал байдаг. Манай улсын хувьд ЖДҮ эрхлэгчдийн нэлээд хэсэг нь худалдаа эрхэлдэг. Гэхдээ хөгжиж буй орнууд чөлөөт худалдааны бодлого баримтлах нь хэрэглээ, үйлдвэрлэлийн хөгжилд аль алинд нь эерэг нөлөөтэйн зэрэгцээ дотоодын зах зээлд сөргөөр нөлөөлөх тал ч бий гэдгийг дурдах нь зүйтэй.

Фрейзер институцийн эдийн засгийн эрх чөлөөний индексийн таван гол талбарын нэг болох олон улсын худалдаанд оролцох эрх чөлөөг тариф, худалдааны зохицуулалтын саад хориг, валютын ханшийн хар зах, капиталын шилжилт болон хүмүүс зорчиход тавих хяналт гэсэн дөрвөн бүлэг үзүүлэлтийн хувьд тооцдог. (Gwartney, Lawson, & Hall, 2013) Монгол Улс 2013 оны “Дэлхийн эдийн засгийн эрх чөлөө 2013” тайланд эдийн засгийн эрх чөлөөгөөрөө 7,06 оноо авч (0-10), 152 улсаас 68-р байранд жагсжээ. Тухайлбал, манай улс олон улсын худалдаанд оролцох эрх чөлөөгөөрөө 6,9 оноо авч, 92-р байранд орсон бөгөөд энэ үр дүн олон улсын худалдаанд оролцоход тарифын болон тарифын бус саад хориг нэлээд ихтэй гэдгийг харуулж байна. Эндээс манай улсын гааль, гадаад худалдааны үйл ажиллагааг зохицуулдаг хууль, эрхзүйн хязгаарлалт худалдаанд оролцогчдод нэлээд түвэг учруулж байна гэсэн дүгнэлт хийж болно. Гэхдээ тухайн улсын гадаад худалдаанд баримтлах нээлттэй, эсвэл дотоодын зах зээлээ хамгаалах бодлого зөвхөн эдийн засгийн асуудал биш, олон улсын түвшин дэх төрийн төвөгтэй асуудал болдог.

Түүвэр судалгааны энэ хэсэгт олон улсын худалдаанд оролцоход ЖДҮ эрхлэгчдэд учирч буй хэлцлийн зардлын эх сурвалжийг тодорхойлж, хэмжлээ. Түүвэр судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн 5,3 хувь нь олон улсын зах зээл дээр бүтээгдэхүүнээ борлуулдаг бол 33,4 хувь нь гаднаас түүхий эд материал, эсвэл хэрэглээний бүтээгдэхүүн импортолдог байна. Тэдний 34 хувь ямар нэгэн тусгай зөвшөөрөл авах шаардлагатай болдог бөгөөд эдгээр аж


ахуйн нэгжийн 61,5 хувь нь гаалийн тусгай зөвшөөрлийг нэг удаа тодорхой хугацаагаар авдаг бол 38,5 хувь нь экспорт, эсвэл импорт хийх бүрдээ авдаг ажээ. Гаалийн мэдүүлэг бөглөж эхэлснээс хойш дунджаар 6-7 хоногийн дараа түүхий эд материал, бүтээгдэхүүнээ хүлээн авч, эсвэл хилээр гадагшаа гаргадаг байна.

**ЗУРАГ 4-7. НИЙТ ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГОД ЭЗЛЭХ ХУВИЙН ТАРХАЛТ**



*Эх сурвалж:* Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

**ЗУРАГ 4-8. НЭГ АЖИЛТАНД НООГДОХ ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН ТАРХАЛТ (ТӨГРӨГӨӨР)**




*Эх сурвалж:* Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

Бид энд ЖДҮ эрхлэгч гаалийн бүрдүүлэлт хийхдээ төлж буй албан ёсны төлбөр хураамж (шууд зардал); гаалийн бүрдүүлэлт хийхдээ ажилтны зарцуулсан цаг, гаалийн байгууллагын шийдвэрийг хүлээнээс тухайн байгууллагад учирч буй зардал болон гаалийн татвар төлөх үйл ажиллагаанд ажилтны зарцуулсан цагийн мөнгөн үнэлгээ (шууд бус зардал); гаалийн тусгай зөвшөөрөл, экспорт, импортын татвар төлөхтэй холбоотой гаалийн албан хаагчдад төлсөн албан бус төлбөр (бэлэг, авлига); хүлээсэн торгууль гэсэн дөрвөн эх сурвалжаар олон улсын худалдаатай холбоотой хэлцлийн зардлыг ойролцоолон хэмжихийг зорилоо. Гадаад худалдаа хийдэг ЖДҮ эрхлэгчдийн гаргаж буй хэлцлийн зардлын дундаж 9,5 сая төгрөг байна. Үүнээс шууд зардал 7,2 сая, шууд бус зардал 2,4 сая, албан бус төлбөр 2,2 сая төгрөг, торгууль 2,4 сая төгрөг байна.

Гадаад худалдаа хийсэн аж ахуйн нэгжүүдийн 58,4 хувь нь жилд дунджаар борлуулалтын орлогынхоо 1 хүртэл хувьтай тэнцэх хэлцлийн зардал гаргасан бол 22,9 хувь нь 3-аас дээш хувьтай тэнцэх хэлцлийн зардлыг гаргажээ. Үүнийг нийт дүнгээр нь авч үзвэл гааль, гадаад худалдааны үйл ажиллагаатай холбоотой нийт хэлцлийн зардал борлуулалтын орлогод 2,9 хувийг эзэлж байгаа бол үүнээс шууд зардал нь 2%, шууд бус зардал 0,9%, албан бус төлбөр 1,1 хувийг тус тус эзэлж байна. Нэг ажилтанд ноогдох хэлцлийн зардал бичил бизнест 943 мянга, жижиг бизнест 1,4 сая, дунд бизнест 612,6 мянган төгрөг байна. (Зураг 4-7, Зураг 4-8)

**ЗУРАГ 4-9. ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ**



*Эх сурвалж:* Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

Гаалийн байгууллагын үйл ажиллагаа хөнгөн шуурхай эсэхийг судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчид хэрхэн үнэлснийг Зураг 4-9-д харууллаа. Үр дүнгээс харвал 33,5 хувь нь маш сайн, сайн гэж үнэлсэн бол 17,1 хувь нь маш муу, муу гэж үнэлжээ.

## **5. ДЭД БҮТЭЦ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЧИНТОЙ ХОЛБООТОЙ ХЭЛЦЛИЙН ЗАРДАЛ**

### **5.1. Дэд бүтэцтэй холбоотой хэлцлийн зардал**

Хөгжиж буй орнуудын суурь дэд бүтцийн хөгжил дорийн байдаг нь эдийн засгийн үр ашгийг бууруулж, бизнес эрхлэх зардлыг нэмэгдуулдэг. Үүнийг Дэлхийн Банк, Дэлхийн Эдийн Засгийн Форумын жил бүр тогтмол хийдэг судалгааны үр дүнгээс тодорхой харж болно. (World Bank, 2014; Schwab & Sala-i-Martín, 2014)

Хангалттай хүртээмжтэй, үр ашигтай дэд бүтцийг бий болгох нь эдийн засаг үр ашигтай ажиллахад чухал ач холбогдолтой. Тодруулбал, дэд бүтцийн хөгжил тухайн улсад хөгжих боломжтой эдийн засгийн үйл ажиллагааны байршил, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, секторыг тодорхойлоход чухал хүчин зүйл болдог. Жишээлбэл, манай улсад сүүлийн жилүүдэд хэрэгжиж буй, хэрэгжихээр төлөвлөгдөж буй том төслүүдийг эхлүүлэхэд суурь дэд бүтцийг бүтээн байгуулах асуудал нэлээд хүч хөдөлмөр шаардаж байгааг бид бэлхнээ харж байна. Дэлхийн Банкны “Бизнес эрхлэхүү 2015” судалгаанд дурдсанаар, Монгол Улс цахилгаанд холбогдох амар хялбар байдлаараа 189 орноос 142-р байранд оржээ. (World Bank, 2014) Энэ нь мөн манай улсад дэд бүтэцтэй холбоотой хэлцлийн зардал өндөр байгааг харуулж байна.


Дэд бүтэц сайн хөгжсөнөөр бус нутгуудын хоорондох зайны нөлөөг бууруулах, үндэсний зах зээлүүдийг нэгтгэх, бусад улс болон бус нутгийн хэмжээнд зах зээлүүдийг бага зардалтайгаар холбох боломжийг олгодог. Үүний зэрэгцээ, дэд бүтцийн чанар болон хүртээмжтэй байдал эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлөөд зогсохгүй ядуурал, тэгш бус байдлыг бууруулахад ч нөлөөлдөг. Тээвэр, харилцаа холбооны дэд бүтцийн хөгжил сайн байх нь эдийн засгийн үйл ажиллагааны гол цөмийг бүрдүүлэгч нийгмийн буурай хөгжилтэй хэсэгт хүрэх урьдач нөхцөл болдог. Сайн чанартай авто зам, темөр зам, усан боомт, агаарын тээврийг үр ашигтай барьж байгуулснаар үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид хүний нөөцөө оновчтой хуваарилах, шилжүүлэх, бараа, үйлчилгээгээ зах зээлд аюулгүй, цаг алдалгүй хүргэх боломж олгоно. Үүнээс гадна, цахилгааны тасалдал, эсвэл хомсдол үйлдвэрүүд саадгүй ажиллахад сөргөөр нөлөөлнө. Найдвартай, хүртээмжтэй холбооны сүлжээ улс орны хэмжээнд мэдээллийн урсгал тасралтгүй, чөлөөтэй явах боломж бүрдүүлнэ. Бизнес эрхлэгчид хоорондоо зардал багатай холбогдож, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг олж авснаар эдийн засгийн үр ашиг нэмэгдэнэ.

Дотоод өсөлтийн онолын загваруудад суурь дэд бүтцийг үйлдвэрлэлийн функцийн бие даасан хүчин зүйл хэлбэрээр суулгаж, үйлдвэрлэлийн бусад хүчин зүйлтэй хослох хэлбэрээр үйлдвэрлэлд хувь нэмрээ оруулна гэж үздэг. Жишээлбэл, нийтийн барааны загварт (Barro, 1990b) засгийн газрын зардлыг цэвэр нийтийн бараа хэлбэрээр тусдаа хүчин зүйл болгож үйлдвэрлэлийн технологид оруулдаг бөгөөд нийтийн бараа нь үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн бүтээмж болон урт хугацааны эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлөхийг баталдаг. Харин дэд бүтцэд хөрөнгө оруулахгүй бол цэвэрлэх байгууламж, цагдаа болон гал түймэртэй тэмцэх, суурь боловсрол зэрэгт хэт их ачаалал үүсэж, нийт үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлдөг болохыг дотоод өсөлтийн загвар харуулдаг. (Barro & Sala-i-Martin, 1992)

Бидний судалгааны энэ хэсгийн зорилго бол манай улсын суурь дэд бүтцийн хөгжил ЖДҮ эрхлэгчдэд хэр зардал учруулж байгааг хэмжих бөгөөд дэд бүтэцтэй холбоотой хэлцлийн зардлын эх сурвалжийг тодорхойлж, үүнээс учрах хэлцлийн зардлыг ойролцоолон хэмжлээ. Судалгааны үр дунгээс харвал нийт судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн 33 хувь нь өнөөгийн дэд бүтцийн хөгжлийг сайн, маш сайн гэж үнэлсэн бол 19,1 хувь нь муу, маш муу, 48 хувь нь дундаж гэж үнэлжээ. Харин дэд бүтцийн хөгжлөөс хамаарч хэр зардал учирч байгааг асуухад ЖДҮ эрхлэгчдийн 72 хувь нь дундаж, их, маш их гэсэн хариултыг өгснөөс


харахад дэд бүтцийн одоогийн хөгжлийн түвшин ЖДҮ эрхлэгчдэд нэлээд зардал учруулж байна. (Зураг 5-1, Зураг 5-2)

**ЗУРАГ 5-1. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ҮНЭЛГЭЭ (ХУВИАР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

**ЗУРАГ 5-2. ДЭД БҮТЭЦ МУУГААС БОЛЖ ГАРАХ НЭМЭЛТ ЗАРДАЛ (ХУВИАР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

Дээрх үнэлгээг ЖДҮ-ийн эдийн засгийн салбар (ХҮСНЭГТ 5-1) болон хэмжээгээр (ХҮСНЭГТ 5-2) харьцуулан харахад, дэд бүтцийн хөгжлөөс хамаарч учрах нэмэлт зардал нь бүх салбарт ойролцоо байдаг бол дунд хэмжээтэй аж ахуйн нэгжүүдээд бичил, жижиг аж ахуйн нэгжүүдээс илүү зардал учруулж байна.

**ХҮСНЭГТ 5-1. ДЭД БҮТЦЭЭС УЧИРЧ БУЙ НЭМЭЛТ ЗАРДАЛ, САЛБАРААР**

	ХАА	Аж үйлдвэр	Үйлчилгээ
Маш бага	13%	7%	10%
Бага	6%	19%	20%
Дундаж	53%	45%	44%
Их	19%	23%	20%
Маш их	9%	5%	6%
<b>Нийт</b>	<b>100%</b>	<b>100%</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

**ХҮСНЭГТ 5-2. ДЭД БҮТЦЭЭС УЧИРЧ БУЙ НЭМЭЛТ ЗАРДАЛ, ХЭМЖЭЭГЭЭР**


	Бичил	Жижиг	Дунд
Маш бага	10%	9%	7%
Бага	19%	20%	20%
Дундаж	47%	45%	40%
Их	18%	18%	28%
Маш их	5%	7%	5%
<b>Нийт</b>	<b>100%</b>	<b>100%</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

Дэд бүтэцтэй холбоотой хэлцлийн зардлыг дараах гурван бүрдэл хэсэгт авч хэмжлээ. Шууд хэлцлийн зардалд зам, талбай өргөтгөх, цахилгаан, дулааны шугам сүлжээ тавих, шинэчлэх ажил болон орчны тохижилттой холбоотой шууд гарах зардлыг багтаав. Шууд бус зардалд цахилгаан тасарснаас тухайн байгууллагын үйл ажиллагаанд учирсан нэмэлт зардал, эсвэл алдагдал, зам засвар болон нийтийн тээврийн saatlaas болж учрах зардал, автомашины дугаарын хязгаарлалтаас болж гарах нэмэлт зардал, зам, талбай өргөтгөх, цахилгаан, дулааны шугам сүлжээ тавих, шинэчлэх ажлаас болж учрах зардлыг оруулав. Харин албан бус төлбөрт төрийн байгууллагын ажилтнуудад өгсөн бэлэг сэлт, авилгыг оруулав.

Нийт судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчийн 53 хувь нь дэд бүтцээс үүдэн ямар нэг хэлцлийн зардалтай тулгарчээ. Эдгээр аж ахуйн нэгжийн 75,3 хувь нь жилд дунджаар борлуулалтын орлогынхоо 1 хүргэл хувьтай тэнцэх хэлцлийн зардал гаргасан бол 15,4 хувь нь 2-оос дээш хувьтай тэнцэх хэлцлийн зардлыг гаргажээ. (Зураг 5-3) Үүнийг нийт дүнгээр нь авч үзвэл дэд бүтэцтэй холбоотой нийт хэлцлийн зардал борлуулалтын орлогод 1,2 хувийг эзэлж байгаа бол үүнээс шууд зардал нь 0,5%, шууд бус зардал 1%, албан бус төлбөр 1,1 хувийг тус тус эзэлж байна. Харин эдгээр ЖДҮ-ийн 40 хувь нь нэг ажилтанд ноогдох дүнгээр 50 мяанганд төгрөгөөс доош хэлцлийн зардал гаргажээ. (Зураг 5-4)

**ЗУРАГ 5-3. ДЭД БҮТЭЦТЭЙ ХОЛБООТОЙ ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН ТАРХАЛТ (БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ХУВИАР)**




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

Хэлцлийн зардлын ачаалал буюу хэлцлийн зардлыг борлуулалтын орлого харьцуулсан харьцаа бичил бизнест хамгийн их байна. (Зураг 5-5) Уг үр дүн бизнес жижиг байх тусам дэд бүтцээс үүдэн гарч буй хэлцлийн зардал илүү дарамттай болж байгааг харуулж байна. Хэлцлийн зардлыг аж ахуйн нэгжийн ажилтны тоонд харьцуулбал, бичил бизнесийн нэг ажилтанд ноогдох хэлцлийн зардал 375,5 мянга, жижиг бизнест 213,3 мянга, дунд бизнес 141,2 мянган төгрөг байжээ. Иймд муу дэд бүтэц нь бичил ба шинэ бизнес эрхлэгчдэд илүү их дарамт учруулж байна.

Дэд бүтцийн өөрчлөлт, хөгжил төрийн бодлого, шийдвэртэй шууд холбогддог учраас төрийн байгууллагуудын үйл ажиллагааны хүртээмжтэй, хөнгөн шуурхай байдал хэлцлийн зардлыг бууруулахад нэн чухал. Түүвэр судалгааны үр дүнгээс харвал, цахилгаан, дулаанд шинээр холбогдох, эсвэл хуучин холболтоо нэмж өргөтгөх хүсэлтийг аж ахуйн нэгжүүдийн 16 хувь нь гаргасны дийлэнх (72%) нь төрийн байгууллага гаргасан хүсэлтийг хуулийн хугацаандаа шийдвэрлэж өгөөгүй гэж хариулжээ. Мөн сүүлийн хоёр жилд зам, талбай өргөтгөх цахилгаан, дулааны шугам сүлжээ тавих, шинэчлэх ажилтай холбоотойгоор үйл ажиллагаанд нь ямар нэг зардал учирсан гэж аж ахуйн нэгжүүдийн 11 хувь хариулсан бол тэдний 14 хувь нь төрийн байгууллагын ажилтнуудад жилд дунджаар 922 мянган төгрөгийн албан бус төлбөр төлжээ. Төрийн байгууллага шийдвэрээ хоцроосон дундаж хугацаа дунджаар 111 өдөр байжээ.


Нийтийн тээвэр, тээврийн зардал бол ЖДҮ эрхлэгчдийн ашигт үйл ажиллагаанд нөлөөлдөг нэг чухал хүчин зүйл юм. Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүд дунджаар 3 автомашинтай байна. Улаанбаатар хотод мөрдөгддөг автомашины дугаарын хязгаарлалт судалгаанд оролцсон аж ахуйн нэгжийн 21 хувьд нь шууд болон шууд бусаар зардал учруулж, орлогыг нь бууруулж байна. Эдгээр ЖДҮ уг нэмэлт зардлыг сард дунджаар 1,5 сая төгрөг гэж үнэлжээ.

**ЗУРАГ 5-4. ДЭД БҮТЭЦТЭЙ ХОЛБООТОЙ ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН ТАРХАЛТ (НЭГ АЖИЛТАНД НООГДОХ ДҮНГЭЭР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

**ЗУРАГ 5-5. ДЭД БҮТЭЦТЭЙ ХОЛБООТОЙ ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГОД ЭЗЛЭХ ХУВЬ (ЖДҮ-ИЙН ХЭМЖЭЭГЭЭР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

Дэд бүтцийн асуудал хариуцсан төрийн байгууллагуудын үйл ажиллагааг ЖДҮ эрхлэгчид хэрхэн үнэлснийг Зураг 5-6-д харууллаа. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг нийт судалгаанд оролцсон аж ахуйн нэгжийн 16,8 хувь нь маш мую, мую гэж үнэлсэн бол 55,2 хувь нь дундаж гэж үнэлсэн байна. Харин 28,1 хувь нь маш сайн, сайн гэж үнэлжээ.

## 5.2. Санхүүгийн байгууллагатай харилцахтай холбоотой хэлцлийн зардал


Хөгжиж буй орнуудад ЖДҮ-ийн санхүүжилтийн орчны талаарх асуудал хамгийн их анхаарал татдаг. Амжилттай, тогтвортой бизнес эрхлэх санаандаа тулгуурлан төслөө бичиж, санхүүжилт авах саналаа санхүүгийн байгууллагад хүргүүлэхэд тавигдах шаардлагыг хангах, хууль эрхзүйн саад хориг, төрийн байгууллагын мую, үр ашигтүй институц, барьцаа хөрөнгө байхгүй зэрэг хүчин зүйлийн улмаас санхүүжилт авч чадахгүй тохиолдол цөөнгүй байдаг. ЖДҮ эрхлэгч бүр том компани болох албагүй ч тэд бизнесээ эхлүүлэх, цаашид өргөтгөх боломжит зардлыг санхүүжүүлэх зөв хэлбэрийг сонгох нийтлэг асуудалтай тулгардаг. Ерөнхийдөө зах зээл дээрх байр сууриа бэхжүүлэх, тогтвортой үйл ажиллагаа явуулах, бизнесээ өргөтгөх, хөгжүүлэх боломж нь санхүүжилт олох, түүнийгээ хэрхэн оновчтой зарцуулах чадвараар шууд тодорхойлогддог. Бизнесийн өсөлтийн ялгаа-тай үе шатуудад ЖДҮ эрхлэгчдийн санхүүжилтийн хэрэгцээ харилцан адилгүй байдаг бөгөөд ажлын капиталын удирдлага, зээл авах, санхүүгийн бусад хэрэгсэл зэрэг нь ЖДҮ эрхлэгчийн бэлэн мөнгөний урсгалд шууд, хамгийн их нөлөөтэй байдаг. ЖДҮ эрхлэгчдийн санхүүжилтийн хэрэгцээ дараах хүчин зүйлээс хамааран ялгаатай байгааг тогтоосон байдаг. (Johnsen & McMahon , 2005), (Zavatta, 2008) Үүнд:

- ✓ Тухайн улс,
- ✓ Үйлдвэрлэлийн сектор,
- ✓ Хүлээж буй бизнесийн эрсдэл,
- ✓ Хөрөнгийн бүтэц, (материаллаг ба материаллаг бус, капитал эрчимтэй ашиглагддаг ба капитал бага ашиглагддаг гэх мэт)
- ✓ Өр ба өөрийн хөрөнгийн харьцаа,
- ✓ Өсөлтийн тувшин,
- ✓ Ашигт байдал.

ЖДҮ эрхлэгчийн санхүүжилт авах боломжтой эх үүсвэрүүдийг дараах үндсэн 6 хэсэгт хувааж болно. (Abe, Troilo, Juneja, & Narain, 2012) Үүнд:

- ✓ Албан бус эх үүсвэрээс санхүүжилт авах, (Хувийн хадгаламж, гэр бүл, найз нөхдөөсөө зээлэх, мөнгө зээлдүүлэгчээс зээлэх, худалдааны зээл гэх мэт.)
- ✓ Дотоод эх үүсвэрээ ашиглах, (Үлдэгдэл ашиг, дотоод хадгаламж, ажлын капитал, хөрөнгө борлуулсны ашиг гэх мэт.)
- ✓ Өрөөр санхүүжүүлэх, (Богино, урт хугацааны зээл, зээлийн шугам, энгийн вексель, зээлийн карт, корпорацийн бонд гэх мэт.)
- ✓ Өөрийн хөрөнгийн санхүүжилт, (Венчур, анхны хөрөнгө, үнэт цаасыг олон нийтэд анх удаа санал болгох гэх мэт.)
- ✓ Хөрөнгөд суурилсан санхүүжилт, (Факторинг, бараа материалын санхүүжилт гэх мэт.)
- ✓ Урт хугацааны түрээс, (Капиталын түрээс, үйл ажиллагааны түрээс гэх мэт.)

**ЗУРАГ 5-6. ДЭД БҮТЭЦ ХАРИУЦСАН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮНЭЛГЭЭ**




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

- ✓ Засгийн газрын буцалтгүй тусlamж ба татаас. (Буцалтгүй тусlamж, зээлийн хүүний татаас, зээлийн баталгаа гаргах хөтөлбөр, зээлийн даатгалын хөтөлбөр гэх мэт.)


Манай улсын хувьд аж ахуйн нэгжийн санхүүжилтийн орчны талаар Монголбанк болон Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банк зэрэг олон улсын байгууллагын хийсэн харьцангуй олон судалгаа байдаг. (Монголбанк, 2011, 2012, 2014) Дэлхийн Банкны 2014 оны судалгаанд Монгол Улс зээл авах хялбар байдлаараа 189 орноос 61-р байранд жагссан бөгөөд 100 онооноос 55 оноо авч, Зүүн болон Номхон далайн орнуудын дундаж (48,6 оноо)-тай ойролцоо дүн авчээ. (World Bank, 2014) Энэхүү түүвэр судалгааны нэг гол зорилго бол төрийн батлан даалт, хөнгөлөлттэй зээлд хамрагдах, санхүүгийн байгууллагуудаас санхүүжилт авахад гарч байгаа хэлцлийн зардлыг хэмжихэд оршино. Судалгаанд оролцсон 1541 ЖДҮ-ийн 25 хувь нь сүүлийн гурван жилд санхүүжилт авч, эсвэл хөрөнгө оруулалт татжээ.

**ЗУРАГ 5-7. САНХҮҮЖИЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ АВСАН ЭСЭХ (ХУВИАР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

**ЗУРАГ 5-8. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ (ХУВИАР)**




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

Хэлцлийн зардал ёсөх нэг эх сурвалж бол мэдээлэл олж авахтай холбоотой зардал бөгөөд түүвэр судалгааны үр дүнд ЖДҮ эрхлэгчдийн 19,7 хувь нь санхүүгийн зах зээлийн талаарх мэдээлэл олж авахад их хүндрэлтэй гэсэн бол 48 хувь нь хүндрэл бага гэжээ. (Зураг 5-8)

Цаашилбал, банк санхүүгийн байгууллагаас зээл авах хүсэлт гаргаснаас хойш дунджаар 13 өдрийн дараа шийдэгддэг гэжээ. (Зураг 5-9) Тухайлбал, судалгаанд оролцсон ЖДҮ-ийн 68,2 хувь нь зээлийн хүсэлт 7 хүртэл хоногийн дотор шийдэгддэг гэж хариулсан бол 17,9 хувь нь 15 болон түүнээс дээш хоног хүлээдэг гэжээ. Энэ түүвэр судалгааны хувьд санхүүгийн байгууллагаас санхүүжилт авах, төрийн батлан даалт, хөнгөлөлттэй зээлд хамрагдахтай холбоотой хэлцлийн зардал шууд болон албан бус зардлын нийлбэрээр тодорхойлогдоно. Шууд зардлыг зээлийн барьцаа бүрдүүлэх, банкны лизингийн бичиг баримт бүрдүүлэх, лизингийн ажил хөөцөлдөх хүмүүсийн цалин хөлс, төрийн хөнгөлөлттэй зээл, эсвэл батлан даалтын бичиг баримт бүрдүүлэх, энэ ажилд оролцсон хүмүүсийн цалин хөлсний нийлбэрээр тодорхойллоо. Харин албан бус төлбөрт төрийн хөнгөлөлттэй зээл, эсвэл батлан даалтад хамрагдахын тулд төрийн байгууллагын ажилтанд өгсөн бэлэг, авлигыг оруулав.

Санхүүжилт татахтай холбоотой нийт хэлцлийн зардал дунджаар 1,4 сая төгрөг бөгөөд үүнийг байгууллагын борлуулалтын орлогод харьцуулбал дунджаар 1 хувь байна. (Зураг 5-


**ЗУРАГ 5-9. ЗЭЭЛИЙН ХҮСЭЛТ ШИЙДЭГДЭХ ХУГАЦАА (ХУВИАР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.


10) Санхүүжилт авахтай холбоотой хэлцлийн зардал гаргасан 496 ЖДҮ-ийн 86,9 хувь нь жилд дунджаар борлуулалтын орлогынхао 1 хүртэл хувьтай тэнцэх хэлцлийн зардал гаргасан бол 8,7 хувь нь 2-оос дээш хувьтай тэнцэх хэлцлийн зардлыг гаргажээ. Үүнийг нийт дүнгээр нь авч үзвэл санхүүгийн байгууллагатай харилцахтай холбоотой нийт хэлцлийн зардал борлуулалтын орлогод 1 хувийг эзэлж байгаа бол үүнээс шууд зардал нь 1%, албан бус төлбөр 1,4 хувийг тус тус эзэлж байна. Уг хэлцлийн зардлыг аж ахуйн нэгжийн ажилтны тоонд харьцуулбал, бичил бизнесүүдэд 225,3 мянга, жижиг бизнесүүдэд 100,6 мянга, дунд бизнесүүдэд 75,1 мянган төгрөгийн хэлцлийн зардал ажилтан тутамд ноогдож байна. Энэ нь бичил бизнесүүдэд харьцангуй илүү дарамт тулгарч буйг харуулж байна.

**ЗУРАГ 5-10. САНХҮҮЖИЛТ АВАХТАЙ ХОЛБООТОЙ НИЙТ ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН ТАРХАЛТ (БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГОД ЭЗЛЭХ ХУВИАР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

**ЗУРАГ 5-11. САНХҮҮЖИЛТ АВАХТАЙ ХОЛБООТОЙ ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН (ТАРХАЛТ НЭГ АЖИЛТАНД НООГДОХ)**




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

ЖДҮ санхүүжилт авахад үүсдэг нэгэн асуудал бол санхүүгийн байгууллагууд барьцаа хөрөнгө шаарддаг явдал юм. Барьцаа хөрөнгөгүйгээсээ болоод зээл авч бизнесээ эхлүүлэх, өргөтгөх, хөрөнгө оруулалт хийх боломжгүй нөхцөл байдал байнга үүсдэг бөгөөд ЖДҮ эрхлэгчид бодлого боловсруулагчдыг энэ асуудалд анхаарлаа хандуулахыг шаарддаг. Түүвэр судалгаанд оролцсон нийт ЖДҮ эрхлэгчдийн 44 хувь нь банк, санхүүгийн байгууллага зээлийн барьцаа хөрөнгө шаарддаг гэж хариулжээ. Зээлийн барьцаа бүрдүүлэхтэй холбоотой гарах шууд зардал дунджаар 2,4 сая төгрөг байгаа нь ЖДҮ-дэд харьцангуй өндөр зардал юм.

Төрөөс ЖДҮ-ийг дэмжих зорилгоор 2012 онд “Зээлийн батлан даалтын тухай” хуулийг батлан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд уг хуулийн хэрэгжилт хэр үр дунтэй байгаа талаар ЖДҮ эрхлэгчдийн санаа бодлыг нарийвчлан судлах шаардлагатай юм. Судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн дөнгөж 3,7 хувь нь төрийн хөнгөлөлттэй зээл, төрийн зээлийн батлан даалтад хамрагдаж байсан гэж хариулснаас үзэхэд уг сангийн хүртээмж бага байна. Эдгээр аж ахуйн нэгж төрийн хөнгөлөлттэй зээл, батлан даалтад хамрагдахын тулд дунджаар 521 мянган төгрөгийн шууд зардал гаргажээ. Төрөөс хэрэгжүүлж буй ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөрийг 16,2 хувь нь маш сайн, сайн гэж үнэлсэн бол 34,6 хувь нь маш муу, муу гэж үнэлжээ. (Зураг 5-12)

**ЗУРАГ 5-12. ЖДҮ-ИЙГ ДЭМЖИХ ТӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ҮНЭЛГЭЭ (ХУВИАР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

## 6. НИЙТ ХЭЛЦЛИЙН ЗАРДАЛ


Өмнөх бүлгүүдэд тооцсон хэлцлийн зардлуудыг нэгтгэн, ЖДҮ-үүдэд тулгараах зах зээлийн бус хэлцлийн зардлын дарамтыг энэ бүлэгт товч авч үзье.

ЖДҮ эрхлэгчид төрийн болон санхүүгийн байгууллагатай харилцах бүхий л үед шатанд гардаг хэлцлийн зардлууд болох шууд зардал (мэдээлэл, зөвлөгөө авах, хураамж төлөх гэх мэт), шууд бус (төрийн байгууллагатай харилцахад зарцуулсан цаг хугацааны зардал буюу алдагдсан боломжийн үнэ), албан бус (тухайн ажлыг хөөцөлдөх явцдаа төрийн албан хаагчдад өгсөн бэлэг сэлт, авилга гэх мэт) зардлыг нийтэд нь хэлцлийн зардалд тооцов. Жилд гарах хэлцлийн зардлыг хэмжихдээ аж ахуйн нэгж шинээр бүртгүүлэх болон хуучин бүртгэлээ шинэчлэх, бизнесийн тусгай зөвшөөрөл авахтай холбоотой хэлцлийн зардлыг энэ удаад оруулаагүй. Учир нь эдгээр хэлцлийн зардал нь тухайн байгууллагын хувьд жил бүр тогтмол гардаггүй, нэг удаагийн шинжтэй хэлцлийн зардал юм. Иймд энэ бүлэгт авч үзэх нийт хэлцлийн зардал нь тухайн аж ахуйн нэгж байгууллагуудад тогтмол тулгардаг зах зээлийн бус хэлцлийн зардлуудыг багтаана. Зарим хэлцлийн зардал жил бүр тогтмол хуваарьтай гардаггүй боловч тухайн жилд уг зардал гарах магадлалыг харгалzan хүлээгдэж буй утгыг нь тооцоонд орууллаа.

Тухайн бизнесийн татвар тайлагналт, мэргэжлийн хяналтын шаардлага биелүүлэх, дэд бүтэцтэй холбогдох, гаалийн үйлчилгээ авах, гэрээний маргаан шийдвэрлүүлэх, төрийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагатай харилцах, санхүүгийн байгууллагатай харилцах зэрэг үйл ажиллагаанд учирч буй зах зээлийн бус хэлцлийн зардлуудыг нэмж нийт хэлцлийн зардлыг тооцов. 2015-2016 онд судалгаанд хамрагдсан 1541 аж ахуйн нэгж сүүлийн нэг жилийн хугацаанд дунджаар 9 сая төгрөгийн зах зээлийн бус хэлцлийн зардлыг дээрх үйл ажиллагаануудад зарцуулжээ. Энэ нь дунджаар аж ахуйн нэгжийн борлуулалтын орлогын 4,4 хувьтай тэнцэж байгаа юм. Үйл ажиллагаа тус бүрдээ ямар хэмжээний хэлцлийн зардал шаардсаныг бид өмнөх бүлгүүдэд нарийвчлан хэлэлцсэн билээ.

Энэхүү хэлцлийн зардал тухайн аж ахуйн нэгжийн борлуулалтын орлоготой харьцуулахад хэр дарамт учруулж байгааг дараах зурагт харуулав. Тухайлбал, борлуулалтын орлогынхоо 20 хувиас дээш хэмжээний хэлцлийн зардалтай тулgarsan аж ахуйн нэгж 4 хувийг эзэлж байгаа бол уг дарамт борлуулалтын орлогын 2 хувиас доош байх аж ахуйн нэгж 58 хувийг эзэлж байна.

**ЗУРАГ 6-1. НИЙТ ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГОД ЭЗЛЭХ ХУВИЙН ТАРХАЛТ**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

**ЗУРАГ 6-2. НИЙТ ХЭЛЦЛИЙН ЗАРДЛЫН АЧААЛЛЫН ХАРЬЦУУЛАЛТ (ХУВИАР)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, судлаачийн тооцоолол.

Хэлцлийн зардлын энэхүү ачааллыг тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны салбар, хэмжээ зэргээр харьцуулж авч үзье.

Зургаас харахад нийт хэлцлийн зардлын ачаалал бичил, жижиг бизнесүүдэд хүндхэн тусч байна. Энэ нь нэг талаас тэдний борлуулалтын орлого харьцангуй бага байдагтай холбоотой

боловч гол нь бичил бизнес эрхлэгчид төрийн байгууллагатай харилцахдаа шаардлагагүй олон шат дамжлага, хүнд сурталтай тулгардгийн илрэл юм. Харин үйл ажиллагааны салбараар авч үзэхэд ХАА-н бизнес эрхлэгчид хэлцлийн зардлын дарамт харьцангуй багатай байдаг бол аж үйлдвэр болон үйлчилгээний салбарын бизнес эрхлэгчид ихээхэн хэлцлийн зардалтай тулгарч байна.

## 7. ДҮГНЭЛТ

Олон улсын болон дотоодын байгууллагуудын олон судалгааны үр дүн хөгжиж буй улс орнуудад жижиг, дунд бизнес хөгжихөд тулгардаг нэг гол бэрхшээл нь төрийн байгууллагуудын хүнд суртал, дарамт шахалт гэдгийг онцолдог. Гэвч манай улсад уг бэрхшээл хэр их хүндрэл учруулдаг талаар хийсэн үнэлгээ ховор байдаг. Бид энэ судалгаагаар бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд төрийн байгууллагатай харилцахад гардаг хэлцлийн зардлыг бизнесийн үе шат бүрээр нарийвчлан хэмжсэн анхны оролдлогыг Үндэсний статистикийн хорооны бизнес регистрийн сангийн өгөгдлөөс бүлэглэх түүвэр ашиглан хийлээ. Хэлцлийн зардлыг төр болон хувийн хэвшлийн хоорондох харилцааны дараах талбаруудад тооцлоо. Үүнд:

- ✓ Албан ёсны бүртгэлтэй холбоотой хэлцлийн зардал,
- ✓ Тусгай зөвшөөрөл ба мэргэжлийн хяналттай холбоотой хэлцлийн зардал,
- ✓ Гэрээний хэрэгжилтэй холбоотой хэлцлийн зардал,
- ✓ Төрийн байгууллагатай харилцахтай холбоотой хэлцлийн зардал,
- ✓ Татвартай холбоотой хэлцлийн зардал,
- ✓ Гааль, гадаад худалдааны үйл ажиллагаатай холбоотой хэлцлийн зардал,
- ✓ Дэд бүтэцтэй холбоотой хэлцлийн зардал,
- ✓ Санхүүгийн байгууллагатай харилцахтай холбоотой хэлцлийн зардал.

Уг судалгаанд төрийн зүгээс бизнес эрхлэгчдэд учруулж байгаа зах зээлийн бус хэлцлийн зардлын гол бүрэлдэхүүн хэсгийг олж илрүүлж, тооцох зорилго тавилаа. Ингэснээр төрийн зүгээс учруулж буй саад тоторыг багасгаж, хялбарчлах, улмаар бизнесийн орчныг сайжруулахад хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

“Зах зээлийн бус хэлцлийн зардал”-д бизнес хийх явцад учирч буй элдэв хүнд суртлыг давахад зарцуулах хүн хүч, цаг хугацаа, албан тушаалтнуудад өгөх авилга зэрэг үр ашиггүй зардлуудыг багтааж үздэг. Хөгжиж буй орнуудад энэхүү зах зээлийн бус хэлцлийн зардлын хэмжээ маш их байдаг нь эдийн засаг, нийгмийн хөгжлийг хойш нь татах гол хүчин зүйл болдгийг судлаачид онцлон тэмдэглэдэг. Судалгааны үр дүнгээс үзэхэд манай улсын ЖДҮ-үүд дунджаар борлуулалтын орлогынхoo 4,4 хувьтай тэнцэх зах зээлийн бус хэлцлийн зардал гаргаж байна. Энэ зардал бичил, жижиг бизнесүүдэд бүр ч илүү дарамт учруулж байна.

Бизнесээ бүртгүүлэх, элдэв зөвшөөрөл хүсэх, тайлагнах зэрэг үйл ажиллагаанд онлайн үйлчилгээг улам гүнзгийрүүлэх шаардлагатай байна. Мөн төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг хүртээмжтэй, ойлгомжтой болгох нь бизнес эрхлэгчдэд учрах хэлцлийн зардлыг бууруулах чухал алхам болохыг судалгаа харуулж байна.

ЖДҮ-үүд төрийн байгууллагатай харилцах үе шат бүрд шууд бус хэлцлийн зардал хамгийн их гарч байна. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллагатай харилцахад шаардагдсан цаг хугацааны үнэ цэн буюу уг ажлыг хариуцсан ажилтнуудын цалин хөлс, төрийн байгууллагын шийдвэр хүлээх хугацааны алдагдал гэх мэт чирэгдэл нь мөнгөн дүнгээр тооцоход маш их зардалтай гарч байна. Иймээс аж ахуйн нэгжүүдэд учруулж буй хэлцлийн зардлыг бууруулахын тулд төрийн байгууллагуудаас шаарддаг элдэв бичиг баримтыг аль болох цөөрүүлэх, төрийн үйлчилгээг шуурхай, хялбар болгох, шат дамжлагыг цөөрүүлэх арга хэмжээг тууштай үргэлжлүүлэх шаардлагатай.

ЖДҮ-үүдийн гаргасан албан бус төлбөр буюу авилгын тохиолдол цөөн, дундаж мөнгөн дүн нь бусад зардалтай харьцуулахад бага байна. Гэхдээ судалгаанд оролцогчид уг асуудлыг бодитой мэдээлээгүй байж болох тул бодит байдал дээр авилгын тархалт, хэмжээ судалгааны дүнгээс их байхыг үгүйсгэх аргагүй. Иймээс нийгэм дэх авилгыг бууруулах чиглэлд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг тасралтгүй үргэлжлүүлэх шаардлагатай.

## **8. АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

- Abe, M., Troilo, M., Juneja, J., & Narain, S. (2012). *Policy Guidebook for SME Development in Asia and Pacific*. Bangkok: United Nations Publications.
- Acemoglu, D., & Johnson, S. (2005). Unbundling institutions. *Journal of Political Economy*, 113(5), 949-995.
- Ayyagari, M., Demirguc-Kunt, A., & Maksimovic, V. (2011, April). Small vs. Young Firms across the World. *Policy Research Working Paper, World Bank*.
- Barro, R. J. (1990b, October). Government Spending in a Simple Model of Endogenous Growth. *Journal of Political Economy*, 98(Part II), S103-S125.
- Barro, R. J., & Sala-i-Martin, X. (1992, October). Public Finance in Models of Economic Growth. *Review of Economic Studies*, 59, 645–661.
- Gwartney, J., Lawson, R., & Hall, J. (2013). *Economic Freedom of the World*.
- Gwartney, J., Lawson, R., & Norton, S. (2014). *Economic Freedom of the World: 2014 Annual Report*. Fraser Institute.
- Johnsen , P. C., & McMahon , R. G. (2005). Cross-Industry Differences in SME Financing Behaviour: An Australian Perspective. *Journal of Small Business and Enterprise Development*, 12(2), 160-177.
- La Porta, R., & Shleifer, A. (2008). Unofficial Economy and Economic Development. *Brookings Papers on Economic Activity*, 275-363.
- Little, I. M., Mazumdar, D., & Page, J. M. (1987). *Small Manufacturing Enterprises: A Comparative Study of India and Other Economies*.
- North, D. (1990). *Institutions, Institutional Change, and Economic Performance*. Cambridge: Harvard University Press.
- Office for National Statistics. (2013). Official House Price Statistics Explained. 1-40.
- Schneider, F., Buehn, A., & Montenegro, C. E. (2010, July). Shadow Economies All over the World. *Policy Research Working Paper*.
- Schwab, K., & Sala-i-Martín, X. (2014). *The Global Competitiveness Report 2014-2015*. World Economic Forum.
- UNDP. (1999, November). Small and Medium Enterprise Development. *Essentials: Synthesis of lessons learned*.
- United Nations. (2008). International Standard Industrial Classification of All Economic Activities, Revision 4.
- WEF. (2014). *The Global Competitiveness Report 2014 - 2015*. Geneva: World Economic Forum.
- World Bank. (2011). *Doing Business: Measuring Business*. Washington, D.C.
- World Bank. (2013). *Enterprise Survey*. Retrieved September 29, 2014, from Enterprise Survey: <http://www.enterprisesurveys.org/Custom-Query/mongolia>
- World Bank. (2014). *Doing business 2015: Going beyond efficiency*. the World Bank.
- World Bank. (2014). *Doing Business 2015: Going Beyond Efficiency*. A World Bank Group Flagship Report.
- World Bank Group. (2014). *Doing Business in Mongolia*. Retrieved September 30, 2014, from Doing Business: <http://www.doingbusiness.org/data/exploreeconomies/mongolia>

- Zavatta, R. (2008). *Financing Technology Entrepreneurs and SMEs in Developing Countries: Challenges and Opportunities*. Washington, D.C.: World Bank.
- Дэлхийн Банк. (2012). *Санхүүгийн салбарын үнэлгээний хөтөлбөр: хөгжлийн модул*.
- Монголбанк. (2011). *Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал*. Улаабаатар.
- Монголбанк. (2011, 2012, 2014). Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал.
- МҮХАҮТ. (2004). *Бичил болон жижиг бизнес*. Улаанбаатар: Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим.
- Нарантуяа, Ч., & бусад. (2009). *Шинэ институцийн эдийн засаг*. Улаанбаатар: Эдийн засгийн бодлого судлалын нийгэмлэг.
- Улсын Их Хурал. (2007). *Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль*. Улаанбаатар.
- Үндэсний Статистикийн Хороо. (2013). *Статистикийн эмхтгэл*. Улаанбаатар.
- YCХ. (2013). 2010 оны НАХ, СХТ: мэдээллийн эх үүсвэр. *Нөөц ашиглалтын хүснэгт, салбар хоорондын тэнцлийн үр дүngийн тархаалтын семинар*. Улаанбаатар хот: Үндэсний статистикийн хороо.
- YCХ. (2015). *Статистикийн эмхтгэл*. Улаанбаатар.